

# ОРЧИН 21

## МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО



### 2-15 ЦАГ ҮЙЛ ЯВДАЛ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН АНХНЫ ХУРАЛДААН БОЛЛОО, САЙД Х.БАДЕЛХАН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН АЖЛЫН ЯВЦТАЙ ТАНИЛЦЛАА



### 16-51 МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ДОТООД СУРГАЛТ СЕМИНАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



### ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ



### 52-56 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

"ДЭД БҮТЭЦ ИНЖЕНЕРИНГ" ХХК  
УС БОЛ ҮНЭЛЭГДЭХ ЁСТОЙ ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ



### 57-67 ХУУЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ,



### 68-69 САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН

"ДЭНЖ ХОТХОН" ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
ЦЭРЭНДЭМБЭРЭЛИЙН ДЭЭДЭНЦЭЦЭГ



### 70-74 ЭРҮҮЛ МЭНД

УС НЬ ТАРГАЛАЛТ, ХАВДАР, ЧИХРИЙН ШИЖНЭЭС  
СЭРГИЙЛЭХ БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ ЭМ ЮМ.

# ОРЧИН 21

### ЭРХЛЭГЧ:

**Б.Пүрэвжав**

/Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Техникийн ухааны магистр, МУ-ын зөвлөх инженер/

### МЕНЕЖЕР:

**Б.Алтантуул**

### ДИЗАЙНЕР:

**Б.Туул**





БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН АНХНЫ ХУРАЛДААН БОЛЛОО

БХБЯ-ны Сайдын зөвлөлийн анхны хуралдаан 2017 оны аравдугаар сарын 30-нд боллоо. Сайдын зөвлөлийн анхны хуралдаанаар Техникийн ухааны доктор Н.Тогтох, Монгол Улсын зөвлөх инженер Н.Даш нарын "Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурын Ердийн болон урьдчилан хүчитгэсэн арматуртай төмөрбетон конусан шон" нэртэй оюуны бүтээлийг танилцуулж, улмаар Төрийн шагналд нэр дэвшүүлэхийг дэмжсэн юм. Уг бүтээлийг Эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам мөн дээрх шагналд дэвшүүлэхээр дэмжиж байв.

Төмөрбетон шонгийн техник технологийн баримт бичгүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлсний үр дүн нь гарсан нийт хэмнэлт нь одоогийн байдлаар 44.5 тэрбум төгрөгт хүрсэн. Байгаль орчинд ээлтэй шугамаар хөдөөг цахилгаанжуулсан, 35 кВ болон 15 кВ-ын цахилгаан шугамаас модон тулгуурыг чөлөөлж төмөрбетон тулгуур болгосноор 238950 модыг сүйтгэлгүй байгальд ургаагаар нь үлдээсэн нь Ойн судалгаа, хөгжлийн төвийн дүгнэлтээр 37.5 тэрбум төгрөгийн ойн нөөц хэмнэгдсэн болох нь ойн экологи-эдийн засгийн үнэлгээгээр тогтоогджээ.



Сайд Х.Баделхан "Манай улсын хувьд өндөр үр ашигтай анхдагч шинэ төмөрбетон бүтээц үйлдвэрлэсэн энэхүү дэвшилтэт технологийг нутагшуулсан,

Барилга, Эрчим хүчний салбарын хөгжил болон Байгаль орчныг хамгаалахад тодорхой хувь нэмэр бүхий инноваци болсон энэ бүтээлд Төрийн шагнал олгохыг баяртайгаар дэмжиж байна" гэв. Тэрбээр Шинэлэг бүхний эхлэл болсон, байгальд ээлтэй, төсөвт хэмнэлттэй ийм таатай мэдээгээр угтсан барилгын салбарын нэрийн хуудас болсон хоёр инженертээ гүнээ талархан хүндэтгэж байгаагаа илэрхийллээ.



## САЙД Х.БАДЕЛХАН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН АЖЛЫН ЯВЦТАЙ ТАНИЛЦЛАА



УИХ-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан БХБЯ-ны хэмжээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн явцтай танилцлаа. Үүнд, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж эхэлж буй "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл" Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламж сайжирч, насос станцууд ба бохирын шугам хоолой шинэчлэгдэн, төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх ажил хийгдэж байгаатай танилцлаа. Мөн БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл" Улаанбаатар хотын VII, XIV дүгээр хороололд 2592 (72\*36) айлын орон сууцны барилга угсралтын ажил, МҮОНРТ, VII хорооллын инженерийн шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж дуусах шатандаа байгаатай танилцсан. Уг төслийн хувьд МҮОНРТ орчмын газар чөлөөлөх ажил удаж байгаагаас саатаж байгааг төслийн зохицуулагчид танилцуулж байв.

Дараа нь БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл" Дорноговь аймгийн Замын-Үүд суманд Дулааны станц, Цэвэр ус бохир усны ариутгах татуургын байгууламж, Цахилгааны дэд өртөө, Зам холбооны байгууламж зэрэг ажлуудыг гүйцэтгэж дуусах шатандаа байгаатай танилцсан. Улсын комисст хүлээлгэж өгөхөд бэлэн болоод байгаа энэ төслийн тухайд Ашиглалтын өмнөх захиргаа байгуулж болох эсэх талаар лавлаж байсан. Учир нь хуулиараа төслийн нэгж нь хуулийн этгээд болохгүй тул ажлаа бүрэн дуусгаж хүлээлгэн өгөхөд асуудал үүсээд байгааг төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Б.Батцэнд ярьж байлаа. Сайд Х.Баделхан "Энэ асуудлыг Засгийн газарт танилцуулсан. Ашиглалтын өмнөх захиргаа байгуулж болохгүй гэсэн. Ажлаа гүйцэтгэсэн нь сайн хэрэг, гүйцэд дуусгачих. Улсын комисс зохих журмын дагуу хүлээж авах байх" гэсэн юм.





Мөн Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Э.Пүрэвжав ажлаа танилцууллаа. Үүний дараа Франц улсын Засгийн газрын зээлээр хэрэгжиж буй "Эрдэнэт хотын бохир ус цэвэршүүлэх байгууламжийн өргөтгөл төсөлтэй танилцсан. "Эрдэнэт хотын 24000 мЗ/хоног хүчин чадал бүхий бохир ус цэвэршүүлэх байгууламжийн өргөтгөлийн ажлыг хийж дуусах шатандаа байна. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн асуудал ид өрнөж байгаатай холбогдуулсан сайдын зүгээс ТЭЗҮ-ийн өртөг хэрхэн гарсан талаар сонирхсон асуултдаа хариулт авч байлаа.

Түүнчлэн Арвайхээр, Даланзадгад, Цэцэрлэг Сайншанд хотуудын цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, өргөтгөлийн ажил хийж буй Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж эхэлж буй "Зүүн өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжил төсөл", НҮБ-тай хамтран хэрэгжүүлж буй барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг багасгах НАМА зэрэг төслийн талаар амжилтын мэдээлэл сонсож, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.





## ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙГ БХБ-ЫН САЙД Х.БАДЕЛХАН АХАЛЖ АЖИЛЛАНА



Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх өнөөдөр /2017.10.24/ Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцлаа. Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцахад УИХ-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, УИХ-ын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, дэд сайд Ц.Цэнгэл, УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нар болон УИХ-ын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ц.Гарамжав нар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Үндэсний хөгжлийн газар, Ус сувгийн удирдах газар зэрэг төрийн байгууллага болон Японы "JICA" олон улсын байгууллагын төлөөлөл оролцов.

Засгийн газрын 2015 оны 450 тоот тогтоолоор шинэ цэвэрлэх байгууламжийг Концессийн гэрээгээр барихаар тусгасан байсан. Энэ дагуу өмнөх Засгийн газрын үед уралдаант шалгаруулалтыг зарлаж, эхний шатанд 5 аж ахуйн нэгж шалгарсан бөгөөд төслийн санал авах эцсийн хугацаанд зөвхөн хоёр нь л материал ирүүлсэн байдаг. Энэ нь Японы "JICA" олон улсын байгууллага болон "Артелиа Вилл энд транспорт" ХХК-иуд юм. Одоогоор тэдгээрийн онцлогийг харьцуулан хэлэлцэх гэхээсээ илүү хэрхэн хурдан цэвэрлэх байгууламжаа барьж эхлэх вэ гэдэг нь чухал болоод байгааг Ерөнхий сайд онцоллоо. Тиймээс Ерөнхий сайд захирамжаа гаргаж ажлын хэсэг байгуулан Барилга хот байгуулалтын сайд Х.Баделханаар ахлуулахаар болов. Ингэснээр дахин сонгон шалгаруулалт зарлан ТЭЗҮ, ажлын зурагтай нь танилцан хөрөнгө босгож ирэх хавар гэхэд Төв цэвэрлэх байгууламжийг барих нь эн тэргүүний зорилтоо болгож байгаагаа ч хэллээ.

Дээрх уулзалтын үеэр УИХ-ын гишүүн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ц.Гарамжав Японы JICA ОУБ-ын ТЭЗҮ-ээр төв цэвэрлэх байгууламжийг барьж эхлүүлэх нь зүйтэй гэдэг саналыг дэвшүүлсэн. Харин Мянганы сорилын сангийн Усны асуудал хариуцсан Ерөнхий захирал Кумар Ранганатан ТЭЗҮ шалгарсан хоёр төсөл хоёулаа сайн төсөл. Японых эхний шатанд одоогийн цэвэрлэх байгууламжийг шинэчилж байж, дараа нь одоогийн лагийг зайлуулах, шинэчилсэн цэвэрлэх байгууламжаас гарах лагийг боловсруулах бол Францын "Артелиа Вилл энд транспорт" ХХК концессын гэрээний дагуу 25-30 жилийн хугацаанд ашиглахдаа 12-15 жилд нь хөрөнгө оруулалтаа нөхнө. Дараа нь монголын талд үнэ төлбөргүй шилжүүлнэ гэж тооцсон юм билээ.



Гэвч нөхцөл байдал 2013 оныхоос , 2015 оныхоос ч эрс өөрчлөгдсөн тул хурдан хугацаанд Төв цэвэрлэх байгууламжаа барихын тулд яаралтайгаар дахин шинээр сонгон шалгаруулалт явуулах нь зүйтэй гэдэг дээр Ерөнхий сайд ч, уулзалтад оролцогчид ч санал нэгдсэн юм. Мянганы сорилтын сангийн хувьд "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжаас гарч буй усыг цэвэршүүлэн дулааны цахилгаан станциудад нийлүүлэх гол зорилго бүхий бидний хамтран хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж буй төслийг хэрэгжүүлэхэд асуудал тулгарсан. Монголын төр засгийн тогтворгүй байдлаас болж төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн барихаар ТЭЗҮ-ээ боловсруулан бэлтгэл ажилдаа ороод байсан компанийн ажил цуцлагдлаа. Мянганы сорилтын корпорацийн хувьд II шатны компакт гэрээнд гарын үсэг зурсны дараа хэрэгжих төсөлд зориулж 350 сая ам.долларын зээлийг олгохоор болсон учир төв цэвэрлэх байгууламжийн санхүүжилтийн асуудлыг шийдэх боломжгүй. Гэхдээ анхнаасаа төв цэвэрлэх байгууламжаас гарч буй бохирыг цэвэршүүлж, дулааны цахилгаан станцид нийлүүлэх замаар Улаанбаатарын усны хангамжийг сайжруулах зорилготойгоор танай яамтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслөө үр дүнтэй болгохын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэхэд шаардлагатай санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газартай хамтран хандивлагч орнуудаас олох боломжийг судалж, гарц хайхад татгалзах зүйлгүй. Үүний тулд бидний цаашдын хамтын ажиллагаа, танай яамны үүрэг чухал гэдгийг онцлох хэрэгтэй" гэсэн юм.

Ийнхүү 53 жилийн нүүр үзэж буй Цэвэрлэх байгууламж У.Хүрэлсүхийн Засгийн газрын хурд, хүчээр шинээр баригдах нь гэсэн найдвар төрж байна. Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн хувьд Монгол гэдэг тусгаар улсын хувьд энэхүү тулгамдсан асуудлаа шийдэх гарц олцгооё. Хугацаа маш бага байна. Ирэх арваннэгдүгээр сард хандивлагч орнууд, хөрөнгө оруулагчдыг урьж төслүүдээ танилцуулья, сонгон шалгаруулалт явуулах ажилд яаравчилья. Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсгийг байгуулна. Энэ ажлын хэсгийг УИХ-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан ахалж, нийслэлийн удирдлагууд болон холбогдох агентлагууд маш хурдтай, чанартайгаар хийж гүйцэтгэхэд гол анхаарлаа хандуул, хугацаанд нь гүйцэтгэхэд хурд, туршлага, чадвар дутаж, тухайн байгууллагаа зөв удирдаж чадахгүйгээс ажил цалгардуулбал хариуцлага тооцно гэдгээ ч хэллээ.





## “УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛО



Хэлэлцүүлгийн зорилго нь Монгол Улсын Ерөнхий сайдаас 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр өгсөн чиглэлийн дагуу Улаанбаатар хотын бохир усны цэвэрлэх байгууламжийн төслийг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэхэд оршино.

Хэлэлцүүлэгт Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Энх-Амгалан, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Стратегийн

удирдлага, зохицуулалтын газрын референт Д.Балжинням, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын албаны дарга Ж.Гэрэлчулуун, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын дарга Ц.Төрхүү, Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын МСК-ийн хооронд байгуулах 2 дахь компакт гэрээ боловсруулах Үндэсний ажлын албаны дарга Э.Содонтогос, "Престиж инженеринг" ХХК-ийн захирал Ш.Ганзориг, төслийн зохицуулагч Б.Солонго, "Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо" төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Б.Пүрэвжав зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамарсан 30 гаруй хүн оролцсон.

Энэхүү хэлэлцүүлгээр дараах илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Үүнд:

1. "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, цаашдын зорилт" Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн;
2. "Улаанбаатар хотод бохир усны цэвэрлэх байгууламжийг шинээр барих ТЭЗҮ"-ийн танилцуулга төслийн зохицуулагч Б.Солонго;
3. "Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацийн хооронд байгуулах 2 дахь компакт гэрээ боловсруулах ажлын явцын тухай" Үндэсний ажлын албаны дарга Э.Содонтогос зэрэг болно.

Дээрх илтгэлүүдтэй холбогдуулан илтгэгчдээс асуулт асууж, санал солилцож, улмаар дараах шийдвэрийг гаргасан. Үүнд:

1. "Артелиа Вил энд Транспорт" компанийн боловсруулсан ТЭЗҮ-г баримтлан Улаанбаатар хотод бохир усны цэвэрлэх байгууламжийг шинээр барих;
2. Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр төслийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр;
3. Төслийг ЕРС буюу түлхүүр гардуулах нөхцөлөөр хэрэгжүүлэх;
4. Цэвэрлэх байгууламжийг шинээр барихын зэрэгцээ одоо ажиллаж байгаа цэвэрлэх байгууламжийн үнэрийг арилгах асуудлыг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хариуцуулан шийдвэрлүүлэх зэрэг болно.

Хэлэлцүүлгийн үр дүнг Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулж, чиглэл авах нь зүйтэй гэж үзлээ.



## **“УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО**

Энэхүү хэлэлцүүлэг нь "ХАЯГДАЛ УС, НӨӨЦ БАЯЛАГ" сэдэвт дэлхийн усны өдрийг угтан зохион байгуулагдаж байгаагаараа онцлог бөгөөд Улаанбаатар хотын ус хангамжийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, тулгамдаж буй асуудлууд, эх үүсвэрийн нөөц, ус хэрэглээнд газрын доорхи болон гадаргын усыг ашиглах хэрэгцээ, шаардлага зэрэг асуудлуудыг хэлэлцлээ.

Хэлэлцүүлэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Туул голын сав газрын захиргаа, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Улаанбаатар хотын Ус сувгийг удирдах газар, Цэнгэг усны хүрээлэн, Монголын геологийн судалгааны төв, Монголын Усны академи зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл 70 гаруй мэргэжилтнүүд, эрдэмтэн багш нар оролцож, илтгэл тавьж хэлэлцүүлэн, зөвлөмж гаргалаа.

Өнгөрсөн хугацаанд тус яамнаас аймаг бүрд 1000 айлын орон сууцны инженерийн шугам сүлжээ барих, "Сумын төвийн шинэчлэл" төсөл, Улаанбаатар хотод "Яармаг", "Буянт-Ухаа", "Баянголын ам" зэрэг орон сууцны 17 иж бүрэн хорооллын эхний ээлжийн барилгажилтын ажлыг инженерийн дэд бүтцийн хамт барьж байгуулах, гэр хорооллыг дахин төлөвлөх, инженерийн дэд бүтэц барих, хот суурин газрын инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах зэрэг томоохон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан. Түүнчлэн Азийн Хөгжлийн банк, БНФранц, БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Хөгжлийн банкны санхүүжилтээр "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл", "Дэд бүтэц төсөл", Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулах төсөл, "Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төсөл", "Дархан хотын бохир усны менежментийн төслүүдийг амжилттай хэрэгжүүллээ.

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласны үр дүнд 2016 оны байдлаар нийт хүн амын 80,6 хувь нь стандартын шаардлагад нийцсэн ундны усаар, 41,1 хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулж, батлуулах, Гадаргын усыг хуримтлуулах замаар хүн амын ус хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор "Туул усан цогцолцор", "Тайшир Алтай" зэрэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, цэвэрлэсэн усыг эргүүлэн ашиглах технологийг нэвтрүүлэх, гэр хорооллыг дахин төлөвлөж, инженерийн дэд бүтэц барих, дэд бүтцийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөж барих зэрэг зорилтуудыг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.





## СӨХ-НЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЛААР НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦЛЭЭ



Б Х Б Я - а а с  
"Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг өнөөдөр зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийг БХБ-ын дэд сайд Ш.Лхамсүрэн, тус яамны НААБХЗГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Лхагвацэдэн нар удирдаж аймаг, нийслэлийн Сууц өмчлөгчдийн холбоодын төлөөлөл, Нийслэлийн болон зарим аймгийн удирдлагууд, орон сууцны барилга байгууламжийн зах зээлд өрсөлдөгчид хүрэлцэн ирж санал бодлоо солилцов.

Нийтийн зориулалттай орон сууцны барилгууд ч олноор баригдаж ашиглалтад орж, 2016 оны байдлаар манай улсын нийт өрхийн 30 хувь буюу 232.3 мянган өрх инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдарч байна. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг сууц өмчлөгчдийн 1022 холбоо, инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг орон сууц, нийтийн аж ахуйн 81 мэргэжлийн байгууллага тус тус хариуцан ажиллаж байна.

Хэлэлцүүлгийн үеэр БХБЯ-ны төлөөллөөс тавьсан илтгэлээс сийрүүлэн хүргэе. Учир нь уг илтгэл хэлэлцүүлэгт оролцогч төлөөлөгчдийн санал шүүмжлэлтэй үндсэндээ ижил байсан. Тиймээс хэлэлцүүлгээс гарсан дүгнэлт, цаашид хэрхэх тухай гарцын талаар ч байр суурь нь яв цав нийцэж байснаараа мэргэжлийн бүтцээр салбарынхаа бодлогыг тодорхойлуулж, хотын дарга асанаар барилгын салбарыг удирдуулсны дүнд СӨХ-ийн талаар болон Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн эерэг, сөрөг талыг тунгаахад урамтай байлаа гэцгээж байсан юм.

Сууц өмчлөгчдийн холбоод нь сууц өмчлөгчдөөс хуримтлуулсан хөрөнгөөр дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна.

УИХ-ын 1999 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого" -ын баримт бичигт "Орон сууцны асуудал нь улсын хөгжил, нийгмийн амьдралын түвшинг тодорхойлох гол үзүүлэлт, хүн амын эрүүл энх, сайн сайхан амьдрах, үр



бүтээлтэй хөдөлмөрлөх язгуур нөхцөл болохын хувьд Монгол Улсын төрийн бодлогын салшгүй нэг хэсэг юм" гэж тодорхойлсон.



Төрөөс иргэдийг орон сууцжуулах, тэдний ая тухтай амьдрах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, барилгуудын насжилтыг нэмэгдүүлэх, СӨХ-дын үйл ажиллагааг дэмжсээр ирсэн.

Энэ хүрээнд 1996 онд "Дундын өмчлөлийн орон

сууцны тухай хууль"-ийг баталж, улмаар 2003 онд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай" хуулийг шинэчлэн баталсан. Энэхүү хууль хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаанд амьдралд хэрэгжихгүй, уг хуулиар зохицуулах шаардлагатай орхигдсон асуудлууд нилээд байсан тул уг хуульд 1997, 1999, 2005, 2011 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулж байсан.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 13 жил өнгөрч байна. Энэхүү хуулийн хүрээнд тус яам сууц өмчлөгчдийн холбоодын талаар дараах эрхийг хэрэгжүүлж, үүргийг хүлээж ажилладаг. Үүнд:

1. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, биелэлтэд хяналт тавих;
2. Орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлт, инженерийн шугам сүлжээ, үндсэн бүтээц, хийцийг өөрчлөхөд тавих шаардлагыг тогтоох;
3. Холбооны үйл ажиллагааг дэмжих;
4. Холбооны үлгэрчилсэн дүрмийг батлах зэрэг болно.

Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаанд тус яам харьяа байгууллага болох "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-аар дамжуулан сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөгөө дэмжлэг, мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж ирсэн.

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ нь Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлтэй хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулан ажиллаж, сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үзлэг, шалгалт хийж, тулгамдсан асуудлаар мэргэжлийн туслалцаа үзүүлж, үзлэг шалгалтын мөрөөр зөвлөмж гаргаж, сууц өмчлөгчдийн холбоодод хүргүүлэн ажиллаж байна.



Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д "Орон сууцны байшингийн ашиглалтын хугацаанд дундын өмчлөлийн эд хөрөнгөд хамаарах дээвэр, цахилгаан шат зэрэгт их засвар хийх үед их хэмжээний хөрөнгө шаардагдах бол барилгын хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн улсын болон орон нутгийн төсвөөс нэг удаа санхүүжүүлж болно" гэж заасан байдаг. Энэ хүрээнд тус яам орон сууцны байшингийн дээвэр, цахилгаан шатны их засварын ажлын тодорхой хэсгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх ажлыг зохион байгуулж ирсэн. 2008-2015 онд нийтийн зориулалттай орон сууцны барилгын дээврийн засварт 10 тэрбум 715 сая төгрөг зарцуулж, 985 барилгын дээвэр, цахилгаан шатны засварт 18 тэрбум 021 сая төгрөг зарцуулж, 1308 цахилгаан шатыг тус тус шинэчилсэн байна. Мөн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.85.5-д "Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх"-д зориулж, улсын төсвөөс 11 тэрбум 280 сая төгрөг зарцуулахаар тусгагдаад байна.

Орон сууцны тухай хуулийн 2011 оны нэмэлт өөрчлөлтөөр хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д орон сууцны байшингийн үндсэн хийц, бүтээцийг анхны зураг төслөөс өөрчлөх, нэмэлт ачаалал өгч давхарлах, өргөтгөл хийхийг хориглох зохицуулалтыг шинээр нэмж оруулсан. Мөн орон сууцны барилгын болон инженерийн шугам сүлжээний төлөвлөлт, ашиглалтын талаар барилгын доорх норм, дүрмүүдийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2014 оны 122 дугаар тушаалаар Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрмийг баталж, сууц өмчлөгчдийн холбоодод хүргүүлж, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд: Салбарын холбогдох байгууллагуудын хамтарсан үзлэг шалгалтаар СӨХ-дын үйл ажиллагаа нь ерөнхийдөө хангалттай түвшинд байна гэж үнэлэгдэж ирсэн боловч иргэд, оршин суугчдын гомдол тасардаггүй, СӨХ-ны үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах хандлага түгээмэл байна.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн дараах зохицуулалтууд хангалтгүй хэрэгжиж ирсэн.

Үүнд:

1. Дээрх хуулийн 7, 8, 9 дүгээр зүйлд холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байх, бүх гишүүдийн 50-иас дээш хувь хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох, уг хурлаар холбооны удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, тэдний үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, холбооны төсөв, тайлан, тэнцлийг хэлэлцэн батлахаар заасан байдаг. Гэтэл сууц өмчлөгчдийн идэвх, санаачлага, оролцоо сулаас хуулийн дагуу ирц бүрддэггүй, ирц бүрдээгүй байхад хурал хийх, бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэх асуудлыг сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал бие даан шийддэг байдал түгээмэл бөгөөд үүнээс шалтгаалж, СӨХ-ны засвар, үйлчилгээний хөлс, зардал, дундын өмчийн эд хөрөнгийн ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон маргаан зөрчил байнга гарсаар ирсэн.





2. Сууц өмчлөгчид нь Иргэний хуулийн 147, 148 дугаар зүйлд зааснаар дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээнд зориулан төлсөн төлбөрөө хэрхэн зарцуулагдаж байгааг мэдэх, хяналт тавих эрхтэй. Гэтэл сууц өмчлөгчид энэхүү эрхээ хэрэгжүүлдэггүй.
3. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газартай холбогдсон зөрчил маргаан цөөнгүй гардаг. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 12.4.8, 18.1.4-т заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга СӨХ-нд гэрээний дагуу газар ашиглуулах эрх олгодог. Тэд энэхүү эрхийг хэрэгжүүлэхдээ сууц өмчлөгчдийн эрхийг зөрчсөн шийдвэрийг цөөнгүй гаргадаг. Тухайн шийдвэрийг үндэслэлтэй олгогдсон эсхийг хянан шийдвэрлэх хугацаанд хамгаалалтын арга хэмжээ авах механизм байдаггүй.
4. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн бүх гишүүдийн хурал зохион байгуулах, удирдах болон хяналтын зөвлөлийн эрх, үүрэгтэй холбоотой заалтууд үндсэндээ хэрэгжихгүй байна.
5. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 15.1-д заасан дундын өмчлөлийн эд хөрөнгийн зааг, ялгааг нарийвчлан гаргах шаардлагатай.



Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар хотхон хорооллын орон сууцны бус зориулалттай техникийн өрөө, нэгдүгээр давхрын үйлчилгээний хэсгүүд автомашины ил, далд зогсоол нь оршин суугчдын дундын өмчлөлд хамаардаг.

Товчхондоо, энэхүү хууль нь тухайн нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, үйлчилгээг хэвийн найдвартай байлгахад оршин суугчдын оролцоог хуульчилсан хууль. Хууль хэрэгжээд 13 жил болжээ. Гэтэл дийлэнх оршин суугчид хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхгүй байна. Тэгэхээр уг хуульд "салхи оруулах" зайлшгүй шаардлагатай гэж хэлэлцүүлэгт оролцогчид ярьж байлаа.

## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ПҮРЭВЖАВ

## МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ДОТООД СУРГАЛТ СЕМИНАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



2017.11.15

д/д	Сургалтын төрөл	Хамрагдах хүний мэргэжил	Огноо	Сургалтын төлбөр
<b>1, Дотоод</b>				
<b>СУРГАЛТЫН ТӨВҮҮДТЭЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР</b>				
1	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын ахлах болон ерөнхий инженерүүдийг чадавхжуулах сургалт	Ахлах болон ерөнхий инженер	1-р сар	195000
2	Цэвэр ба бохир усны насосны станцын машинистын бэлтгэх сургалт	Машинист	1-р сар	250000
3	Усны шинжилгээний лабораторийн химичийг чадавхжуулах сургалт	Химич	1-р сар	200.000
4	Усны тоолуурын засварчныг бэлтгэх сургалт	Засварчин	3-р сар	210.000
5	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын дулаан хангамж, горим тохируулгын инженерүүдийг чадавхжуулах сургалт	Дулаан хангамж, горим тохируулгын инженер	3-р сар	195.000
6	НАА-н салбарын нягтлан бодогчдыг чадавхжуулах сургалт	Нягтлан	3-р сар	195.000
7	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын ус хангамжийн инженерүүдийг чадавхжуулах сургалт	Ус хангамжийн инженер	4-р сар	195.000
8	НАА-н салбарын хүний нөөцийн менежерийн мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт	Хүний нөөцийн менежер	4-р сар	195.000
9	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээний инженерүүдийг чадавхжуулах сургалт	Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээний инженер	4-р сар	195.000
10	НАА-н салбарын удирдах ажилтны сургалт	Удирдах ажилтан	10-р сар	
11	Цахилгааны инженер болон цахилгаанчдыг чадавхжуулах сургалт	Цахилгааны инженер болон цахилгаанчин	10-р сар	195.000
12	Сантехникийн засварчны бэлтгэх сургалт	Засварчин	10-р сар	250.000
13	Усны шинжилгээний лабораторийн бактериологичийг чадавхжуулах сургалт	Бактериологич	11-р сар	200.000
<b>2. Орон нутагт зохион байгуулах сургалт</b>				
14	"Дулаан Шарын гол" ТӨҮГ	Инженер техникийн ажилтан, Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу	
15	"Дундговь Ус суваг" ОНӨҮГ	Инженер техникийн ажилтан, Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу	
16	"Ундарга" ХХК	Инженер техникийн ажилтан, Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу	



БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ПҮРЭВЖАВ

**Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны 2018 онд олон улсад зохион байгуулах сургалт, семинарын төлөвлөгөөний холбоо төлөвлөгөөний холбоо**

2017.11.15

№	Олон улсад зохион байгуулагдах сургалт, семинар, үзэсгэлэн бага хурал	1048112 УХЗ 093 Үзэсгэлэн, сургалт, семинар болох улс	Хугацаа	Хамрагдах хүний тоо	Очих улс	Нийт зардал
1,	Япон улсын Шизуока, Яманаш хотын Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах 7 хоногийн сургалт. Сургалтаар ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, холбоо тогтоох, одоо ашиглагдаж байгаа шинэ техник технологи, тоног төхөөрөмжийн ашиглалттай танилцаж өөрийн оронд нэвтрүүлэх боломж, бололцоог судална.	Япон улсын Шизуока, Яманаш хот	I сард	8	Япон улсын Шизуока, Яманаш хот Токио хот Нийт 9 хоног	2000 \$
2,	Москва хотод 11/06-09-нд Ус хангамж, дулаан хангамж, агаар сэлгэлт, сантехникийн тоног төхөөрөмжийн дэвшилтэт техник технологийн танилцуулга болсон олон улсын үзэсгэлэн яармаг болно. Тус арга хэмжээнд 30 гаруй улс орны 700 байгууллага оролцдог бөгөөд ус, дулаан, агааржуулалтын системд нэвтрүүлж буй шинэ санаа, ололт амжилтаа танилцуулах болно.	ОХУ-ын Москва хот	11/05-11	8	Москва хот	3,800,000 төгрөг
3,	2 жилд нэг удаа зохион байгуулагддаг Байгаль орчин ба Ус, бохир ус, хог хаягдлын менежмент "IFAT Munchen 2018" олон улсын үзэсгэлэн, бага хурал ХБНГУ-ын Мюнхэн хотноо 11/14-18-ны өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна. Дэлхийн 100 гаруй улс орны ус ашиглалтын байгууллагын удирдлагууд, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, эрдэмтэн судлаачид оролцон ус, бохир ус, хог хаягдалтай холбоотой асуудлын шийдлийг олох зорилготой олон улсын томоохон арга хэмжээ юм. Тус арга хэмжээнд оролцсоноор олон улсын байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, тэргүүн туршлага техник технологитой танилцаж, өөрийн оронд нэвтрүүлэх боломж, бололцоог судална.	ХБНГУ-ын Мюнхэн хот	11/14-23	9	Герман, Итали, Швейцарь, Франц, Австри Нийт 10 хоног	3,100 €





4,	Aquatech China 2018	Байгаль орчин, Ус хангамж, ариутгах татуурга, сантехникийн тоног төхөөрөмжийн хамгийн сүүлийн үеийн шинэ техник технологи, техникийн шийдлийн талаар танилцуулга хийсэн томоохон үзэсгэлэн болно. Үзэсгэлэнгээр ус хангамж, ариутгах татуургын системд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шинэ санааг танилцуулж, туршлага солилцож 1400 гаруй компани тоног төхөөрөмжийн үзэсгэлэн гаргаж оролцох болно.						
5,	11th annual WaterSmart Innovations Conference and Exposition 2018	Хот суурин газрын ундны усны нөөцийн хамгаалалт, эрэлт ба нийлүүлэлтийн менежмент, усыг дахин ашиглах, усыг үр ашигтай зарцуулах сэдвүүдээр дэлхийн өнцөг булан бүрээс инженер, эрдэмтэн судлаачид хүрэлцэн ирж шинэ санаа болон санал бодол, туршлага солилцсон бага хурал зохион байгуулагдаж, ус хангамж инженерийн шугам сүлжээнд ашиглагдаж буй дэвшилтэт техник технологи, техникийн шийдлийн талаар үзэсгэлэн тавигдана. Тус арга хэмжээнд оролцсоноор олон улсын шинэ техник технологитой танилцаж, өөрийн оронд нэвтрүүлэх боломж, бололцоог судална.	АНУ-ын Лас-Невада мужийн Лас Вегас хот	X103-12	10	АНУ-н Лас-Вегас, Сан Франциско хот, Лос Анжелс Нийт 10 хоног	3900 \$	
6,	"Орон сууц, ус ашиглалтын менежмент"	ОСНАА-н салбарын удирдах ажилтан, инженер техникийн ажилтны 7 хоногийн сургалт. Сургалтаар Солонгос улсын Орон сууц, ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж туршлага судалж, одоо ашиглагдаж байгаа шинэ техник технологи, тоног төхөөрөмж, хууль эрх зүйн акт баримт бичигтэй танилцаж өөрийн оронд нэвтрүүлэх боломж, бололцоог судална.	Солонгос улсын Сөүл хот	9-р сард тохиролцсоны дагуу	8	Солонгос улсын Сөүл хот Нийт 7 хоног	1800 \$	

Жич: Тухайн төлбөрт урилга, визний хураамж, ирэх очих онгоцны билет, сургалт, үзэсгэлэн, семинар, үзвэр, унаа, аялалын зардал, буудал, хоолны үнэ багтсан бөгөөд тухайн үед бага зэрэг өөрчлөгдөж болно.

Төлөвлөгөө гаргасан: Сургалтын менежер

Б.Алтантуул



## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 5 ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ БОЛЛОО

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 5 жилийн тайлангийн хурал 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Гэгээнтэн цогцолборын 3 давхрын 4-р танхимд зохион байгуулагдлаа.



Тайлангийн хуралд Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн захирагчийн ажлын алба, Шударга, өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо, аймаг, нийслэлийн нийтийн аж ахуйн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын удирдах ажилтнууд зэрэг нийт 120 гаруй төлөөлөгчид оролцсон байна.





Тус хурлаар "Ус хангамж, ариутгах татуургын салбарын зохицуулалт, үр дүн", "Ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зохицуулалт", "Нийтийн аж ахуйн байгууллагуудын санхүүгийн байдал", "Ус хангамж, ариутгах татуургын салбарт дахь мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа", "Эрчим хүчний салбарын зохицуулалтын туршлага", "Нийтийн аж ахуйн салбарын цаашдын хөгжлийн чиг хандлага", "Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өнөөгийн байдал, цаашдын зорилт", "Ус хангамж ариутгах татуургын салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах", "Ус хангамж, ариутгах салбарын мэргэжилтэй боловсон хүчний хангалт, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарах асуудал" зэрэг сэдвийн хүрээнд илтгэлүүд тавигдсан. Мөн Зохицуулах зөвлөлөөс сүүлийн 5 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлангаа салбарын төлөөлөгчдөд танилцуулсан юм.

Шагналын гардуулах арга хэмжээний хүрээнд:

1. Салбартаа хөдөлмөр, зүтгэлээрээ тэргүүлэн ажилласан хичээл, зүтгэлийг нь өндрөөр үнэлж төрийн дээд медаль болон "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар Зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын албаны дарга Ж.Гэрэлчулуун, "Нийтийн аж ахуйн салбарын тэргүүн"-ээр Зохицуулах зөвлөлийн Тусгай зөвшөөрлийн албаны дарга Л.Хишигдулам нарыг тус тус шагнав.







2. Зохицуулах зөвлөлийн анхны дарга Ч.Эрдэнэчимэг, Тусгай зөвшөөрлийн албаны дарга асан П.Долгорсүрэнг Зохицуулах зөвлөлийн хүндэт жуух бичгээр, "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ, "Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ, "Онги ус суваг" ОНӨААТҮГ, "Жинст өргөө" ХХК-ыг Зохицуулах зөвлөлийн хүндэт өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагналаа



3. "Дэд бүтэц инженеринг" ХХК-тай хамтран зохион байгуулсан "Тоолууржуулах аян"-ны хүрээнд шалгарсан "Дархан ус суваг" ХК, "Гүний ус" ХХК-иудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнасан.
4. "Усны тэгш, хүртээмжтэй тариф WASH-411 төсөл"-ийн хүрээнд "Төв чандмань" ОНӨААТҮГ, "Багануур-ус" ОНӨААТҮГ, "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ыг иж бүрэн комьютерээр тус тус шагналаа.

МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНХЗАЯА



## “МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО” МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН БҮХ ГИШҮҮДИЙН ЭЭЛЖИТ IY ХУРАЛ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Аймаг, нийслэлийн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар нь Оршин суугч иргэд, байгууллагуудад ундны цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэх, халаалт, цахилгаанаар хангах, хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах тэдгээрийн инженерийн байгууламж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган, иргэдэд хамгийн ойр нэн шаардлагатай хариуцлагатай үйлчилгээг хариуцан ажилладаг чухал салбар билээ.

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны Бүх гишүүдийн ээлжит IY хурал 10 дугаар сарын 26-нд Улаанбаатар хотноо боллоо.

Ээлжит хуралдаанд аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 50 гаруй байгууллагаас мандаттай 42, урилгаар 6 төлөөлөл оролцож 84%-ийн ирцтэй амжилттай зохион байгуулагдлаа.

Хурлаар өнгөрсөн 4 жилд холбооноос зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил болон цаашдын зорилтын талаар тайланг хэлэлцэж, БХБЯамны ОСНААБХЗГазрын дарга О.Лхагвацэдэн мэдээлэл хийж, салбарын ажлын талаар санал шүүмжлэл өрнүүлж салбарын өмнө тулгамдаж буй шийдвэрлэх шаардлагатай олон асуудлуудыг хөндөн ярилцсан бөгөөд тус хурлаас санал гомдлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны тэргүүн Ж.Батсуурь "Холбоо 2005 онд байгуулагдан өнөөдрийн энэ өдрийг хүртэлх 13 дахь жилдээ үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирлээ. Төрийн бус байгууллага тасралтгүй үйл ажиллагаа явуулахад амар хялбар байгаагүй ч та бүгдийнхээ дэмжлэгтэйгээр амжилттай ажиллаж байна" хэмээн Орон сууцны ашиглалт, үйлчилгээ, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын орон нутгийн болон нийслэлийн байгууллагуудаас төлөөлөн оролцож буй төлөөлөгчдөд ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж мэндчилгээ дэвшүүлж, хурлыг тэргүүлэн зохион байгууллаа.







Хурлаар холбооны гүйцэтгэх захирал Б.Пүрэвжав "Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо" Мэргэжлийн төрийн бус байгууллагын 2013-2017 оны 4 жилийн хугацаанд хийсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудлын талаар илтгэл тавьлаа.

Мөн холбооны нягтлан бодогч Л.Лхамаасүрэн холбооны 2013-2017 оны 4 жилийн санхүүгийн тайлан, мэдээнд Хяналтын зөвлөлөөс тавьсан хяналт шалгалт, дүгнэлтийг танилцууллаа.



БХБЯам ОСНААБХЗГазрын дарга О.Лхагвацэдэн Төрөөс Нийтийн аж ахуйн салбарт баримтлах бодлогын шинэчлэл, хэрэгжүүлэх арга зам, НААҮ-ний салбарт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар мэдээлэл хийлээ.



Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Э.Пүрэвжав Холбооны Бүх гишүүдийн ээлжит IY хуралд оролцогчдод ажлын амжилт, хүсч мэндчилгээ дэвшүүлж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүслээ.







Хуралд оролцсон гишүүн байгууллагын төлөөллүүд өнгөрсөн 4 жилд холбооноос зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил болон цаашдын зорилт, тайлангийн талаар асуулт асууж, санал хэллээ.

Сүүлийн жилүүдэд тус салбарын байгууллагуудад шийдвэрлэгдээгүй олон асуудал хуримтлагдсанаас ажиллагсдын дундаж цалин 600 орчим мянган төгрөг байгаа нь бусад салбаруудтай харьцуулахад хамгийн бага учир ялангуяа инженер техникийн болон дадлага туршлагатай мэргэжилтэй ажилтнууд барилга, уул уурхай зэрэг бусад салбарт шилжин, мэргэжилтэй ажиллагсдын хүрэлцээ хомсдсоор байна.



Төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх ажлыг тус салбарт хэрэгжүүлмээр байна. Салбарын инженер техникийн ажилчид болон мэргэжлийн ажиллагсад давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох ажлыг мэргэжлийн төрийн бус байгууллагад шилжүүлэх, ингэснээр төрөөс салбартаа үзүүлэх үйлчилгээний давхардал арилж байгууллага, ажиллагсдын хариуцлагын тогтолцоог сайжруулах боломж бүрдэнэ.

Манай салбарын байгууллагуудын бүтэц, санхүүгийн чадавхи харилцан адилгүй байгаагаас зах зээлийн харилцаанд бүрэн шилжиж чадахгүй байна; гэхмэтчилэн саналуудыг аймаг, орон нутгийн дарга нар хэлж байлаа.

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, хандивлагч орнуудын дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх зээл, зээлийн хүүгийн асуудлыг шийдвэрлэх явдал хэтэрхий удаашралтай байгаад тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. Төслүүдийн нийт өрийг хөрөнгө болгон хувиргах замаар шийдвэрлэх.

Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрөөс учирч байгаа санхүүгийн алдагдлыг жил бүр орон нутгийн төсвөөс татаас олгуулах талаар Засгийн газрын 2012 оны 209 тоот тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах.

Орон нутгийн өмчит байгууллагуудын ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын асуудлыг хуулийн дагуу журам боловсруулж аймгийн төвийн сум, суурин газрын Ундны эх үүсвэрийн хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, дотоодын цэргийн хамгаалалтаар хамгаалах ажлыг эхлүүлэх, гэх мэт саналуудыг дэвшүүлж байлаа.

Мөн хурлаар 4 байгууллагад холбооны Гишүүний гэрчилгээ гардууллаа.

- "Чандмань Бадрал" ХХК
- ОСНАА Мэргэжлийн холбоо ТББ
- "Талын Илч" ОНӨҮГ
- "Бат Баян Дулаан" ХХК







Барилга хот байгуулалтын яамны **"НИЙТИЙН АЖ АХУЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН"** цол тэмдгээр:

- Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ОНӨҮГ-н Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн
  - Ховд аймгийн Шим Ус ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Нямлхагва нарыг шагналаа.
- МНААҮХолбоо Мэргэжлийн төрийн бус байгууллагын **"МӨНГӨН ОД"** хүндэт тэмдгээр:
- Налайх дүүргийн Чандмань Налайх ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Чулуунбат
  - Багануур дүүргийн Багануур Ус ОНӨҮГазрын гүйцэтгэх захирал М.Буддорж нарыг шагнаж урамшууллаа.

МНААҮХолбоо Мэргэжлийн төрийн бус байгууллагын **"Хүндэт өргөмжлөл"**-өөр Өмнөговь аймгийн Гүний Ус ХХК-ийн Ус түгээгч Ё.Үзмээг тус тус шагнаж урамшууллаа.

"БҮХ ГИШҮҮДИЙН ЭЭЛЖИТ ИҮ ХУРАЛ"-д оролцсон Орон нутгийн НАА-н үйлчилгээний байгууллагуудын дарга нарын төлөөлөл БХЯамны ОСНААБХЗГазрын дарга О.Лхагвацэдэн, мэргэжилтэн Д.Мөнхбаатар, Б.Оюунчимэг, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын НАА-н хэлтсийн дарга Т.Мөнхбаатар, мэргэжилтэн н.Мөнхбаатар нартай уулзаж Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын болон орон нутгийн байгууллагын өмнө тулгамдаж буй шийдвэрлэх шаардлагатай олон асуудлын талаар санал солилцож, шийдвэрлэх тал дээр хатмран ажиллахаар боллоо.



Шинээр томилогдсон БХБайгуулалтын сайд Х.Баделхантай "Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо" Мэргэжлийн төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн дарга Ж.Батсуурь, гүйцэтгэх захирал Б.Пүрэвжав, Б.Туул, Ч.Нина нарын хамт уулзалт зохион байгуулж. НАА-н салбарын өнөөгийн байдлын талаар танилцуулга хийж, Бүх гишүүдийн ИҮ хурлаас гарсан саналуудыг нэгтгэсэн албан бичиг өгч, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан "Төрийн байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх" заалтыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх санал дэвшүүлж бидний саналыг найрсагаар хүлээн авч салбарын өмнө шийдвэрлэх шаардлагатай байгаа асуудлуудыг хамтран шийдвэрлэж, ажиллахаар боллоо.





## МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2017 ОНЫ III УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ СЕМИНАР

Хот, орон нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын удирдлага болон инженер техникийн ажиллагсдыг бэлтгэх, мэргэжил, мэдлэг, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх мэргэжлийн сургалтыг зохион байгуулахаас гадна салбарын ажлын чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэнд оролцож, хөгжилтэй орны зорилго нэгтэй байгууллагатай хамтран ажиллаж туршлага судлах, харилцаа холбоо тогтоож, тэргүүн туршлага, техник технологитой танилцаж өөрийн улс орондоо нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс Хятад улсын Шанхай хотноо жил бүр зохион байгуулагддаг "AQUATECH CHINA 2017" олон улсын үзэсгэлэнд НАА-н салбараас 35 хүний бүрэлдэхүүнтэй оролцоод ирлээ.

Тус үзэсгэлэнгээр Байгаль орчин, Ус хангамж, ариутгах татуурга, сантехникийн тоног төхөөрөмжийн хамгийн сүүлийн үеийн шинэ техник технологи, техникийн шийдлийн талаар танилцуулга хийсэн томоохон үзэсгэлэн боллоо.

Бид тус үзэсгэлэнд оролцсоноор олон улсын байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, тэргүүн туршлага техник технологитой танилцаж, өөрийн оронд нэвтрүүлэх боломж, бололцоог судаллаа.








- Мөн АНУ-н Лас Вегас хотноо 10 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа "WaterSmart Innovations Conference and Exposition 2017" олон улсын үзэсгэлэн, бага хуралд Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбараас 11 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцоод ирлээ.

Тус бага хурал, үзэсгэлэнгээр Хот суурин газрын ундны усны нөөцийн хамгаалалт, эрэлт ба нийлүүлэлтийн менежмент, усыг дахин ашиглах, усыг үр ашигтай зарцуулах сэдвүүдээр дэлхийн өнцөг булан бүрээс инженер, эрдэмтэн судлаачид хүрэлцэн ирж шинэ санаа болон санал бодол, туршлага солилцсон бага хурал зохион байгуулагдаж, ус хангамж инженерийн шугам сүлжээнд ашиглагдаж буй дэвшилтэт шинэ техник технологи, техникийн шийдлийн талаар үзэсгэлэн тавигдлаа.



Бид энэхүү арга хэмжээнд оролцсоноор олон улсын шинэ техник технологитой танилцаж, өөрийн оронд нэвтрүүлэх боломж, бололцоог судалсан.





- ХБНГерман улсын Саксон мужийн Эдийн засаг, хөдөлмөр, тээврийн яам болон Заксоны эдийн засгийн хамтын ажиллагаа ХХК-аас зохион байгуулсан Саксен мужийн Эрчим хүч, байгаль орчин, дэд бүтцийн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай туршлага судлах аичлал, сургалтад НАА-н холбооноос 6 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцоод ирлээ.

Заксен Эдийн засгийн дэмжлэг ХХК-аас Байгаль орчин, эрчим хүчний технологи, дэд бүтцийн чиглэлд хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын ААН, байгууллагууд, орон нутгийн төлөөллийг Заксен муж улсад танилцах аялал хийх ажлыг санаачилсан. Энэхүү санаачлагын хүрээнд хийгдэх аялалын Заксен муж улсад гарах зардлын тодорхой хэсгийг Заксен муж улсын Эдийн засаг, хөдөлмөр, дэд бүтцийн яамны эх үүсвэр Салбарын хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлсэн болно.

Энэхүү сургалт айлчлалаар Орчин үеийн техник технологи, шийдэлтэй танилцаж туршлага судлах, хамтран ажиллах болон тоног төхөөрөмжүүдийг Монголдоо нэвтрүүлэх боломжуудыг тодорхойлох, судлах байлаа.

Сургалтаар Дрезден хот, Фрайбэрг хот, Лайпцэг хотуудын Бохир ус цэвэрлэх байгууламж, Ус сувгийн байгууллага, Сэргээгдэх эрчим хүчний техник технологи үйлдвэрлэгч байгууллагууд, Барилгын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх Сургалт үйлдвэрлэлийн төв гэх мэт холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж туршлага судаллаа.



Бид салбарын ажилчдад мэдлэг, чадварыг эзэмшүүлэхээс гадна мэргэжлийн зөвлөгөө өгч чадварлаг ажилчидтай болох сонголтыг тань үргэлж дэмжин ажиллах болно.

Сургалтын менежер Б.Алтантуул



## ТӨВИЙН БҮСИЙН НАА-Н БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СПОРТ УРЛАГИЙН НААДМЫН ТАЙЛАН

Төвийн бүсийн НАА-н байгууллагуудын дунд зохион байгуулсан урлаг, спортын наадмыг 2017 оны 5-р сарын 18-20-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд НАА-н "Урсгал-Ус" ХХК хүлээн авч, зохион байгуулсан.

Уг урлаг спортын тэмцээнд дараах байгууллагууд хүрэлцэн ирж оролцсон. Үүнд:

1. Барилга хот байгуулалтын яамны Орон сууц НААҮ-ны хэлтэс
2. Улаанбаатар хот Хувийн орон сууц НАА-н хөгжлийн төв ТББ
3. Улаанбаатар хот Орон сууц НАА-н мэргэжлийн холбоо ТББ
4. Улаанбаатар хот УСУГ
5. Орон сууц НААҮ-ний удирдах газар
6. Сэлэнгэ аймаг Сайхан сум "Гавшгай Ус" ХХК
7. Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум "Урсгал Ус" ХХК
8. Дархан "Ус суваг" ХК
9. Сэлэнгэ аймаг Мандал сум "Цант-Орхон" ХХК тус тус оролцсон болно.

### **Зохион байгуулсан тэмцээний төрлүүд:**



- Урлагийн мэндчилгээ
- Футзал /эр/
- Сагсан бөмбөг /эм/
- Ширээний теннис /эр, эм/
- Билльярд /дарга нар/
- Шагайн харваа
- Буухиа гүйлт /2 эр, 2 эм/ тус тус зохион байгуулж явуулсан.







**Урлагийн мэндчилгээгээр:**

- 1-р байр – Сэлэнгэ "Урсгал-Ус" ХХК
- 2-р байр – Дархан "Ус Суваг" ХК
- 3-р байр – Улаанбаатар "Хувийн орон сууц НАА-н хөгжлийн төв" ТББ

**Футзалны төрөлд:**

- 1-р байр – Улаанбаатар УСУГ
- 2-р байр – Сэлэнгэ "Урсгал-Ус" ХХК
- 3-р байр - Улаанбаатар "Хувийн орон сууц НАА-н хөгжлийн төв" ТББ



**Сагсан бөмбөгийн төрөлд:**

- 1-р байр – Улаанбаатар УСУГ
- 2-р байр – Дархан "Ус Суваг" ХК
- 3-р байр - Улаанбаатар "Хувийн орон сууц НАА-н хөгжлийн төв" ТББ

**Ширээний теннисний төрөлд IэрI:**

- 1-р байр - Улаанбаатар УСУГ
- 2-р байр - Дархан "Ус Суваг" ХК
- 3-р байр - Улаанбаатар "Хувийн орон сууц НАА-н хөгжлийн төв" ТББ



**Ширээний теннисний төрөлд IэмI:**

- 1-р байр - Орон сууц НАА-н мэргэжлийн холбоо ТББ
- 2-р байр - Улаанбаатар УСУГ
- 3-р байр – Сэлэнгэ аймаг Мандал сум "Цант-Орхон" ХХК

**Шагайн харваан төрөлд:**

- 1-р байр – Сэлэнгэ "Урсгал-Ус" ХХК
- 2-р байр –Улаанбаатар УСУГ
- 3-р байр - Дархан "Ус Суваг" ХК

**Буухиа гүйлтийн холимог төрөлд:**

- 1-р байр – Улаанбаатар УСУГ
- 2-р байр –Сэлэнгэ "Урсгал-Ус" ХХК
- 3-р байр - Улаанбаатар "Хувийн орон сууц НАА-н хөгжлийн төв" ТББ

**Билльярдны төрөлд:**

- 1-р байр – Сэлэнгэ "Урсгал-Ус" ХХК
- 2-р байр – Улаанбаатар "Хувийн орон сууц НАА-н хөгжлийн төв" ТББ
- 3-р байр - Улаанбаатар УСУГ тус тус байр эзэлсэн.







**Уг наадамд багийн дүнгээр:**

1-р байр – Улаанбаатар УСУГ /Өргөмжлөл, 2,000,000 төгрөг/

2-р байр –Сэлэнгэ "Урсгал-Ус" ХХК /Өргөмжлөл, 1,500,000 төгрөг/

3-р байр - Орон сууц НАА-н мэргэжлийн холбоо ТББ /Өргөмжлөл, 1,000,000 төгрөг/

тус тус багууд шалгарч шагнал гардуулсан. Мөн төрөл тус бүрт байр эзэлсэн баг тамирчдад медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулан өгсөн.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН "УРСГАЛ-УС" ХХК**



## БАРУУН БҮСИЙН УРЛАГ, СПОРТЫН НААДМЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Жил бүр уламжлал болон явагддаг нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын баруун бүсийн урлаг, спортын наадмыг 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний хооронд Увс аймгийн Улаангом хотод амжилттай зохион байгууллаа.

Тус тэмцээнд Увс аймгийн "Чандмань-Увс" ХХК, Говь-Алтай аймгийн "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ, Завхан аймгийн "Амь-Ус Трейд" ХХК, Ховд аймгийн "Шим-Ус" ХХК, Баян-Өлгий аймгийн "Суат" ХХК-ийн баг, тамирчид оролцлоо.

Спортын төрлөөр гар бөмбөгийн холимог баг, сагсан бөмбөгийн холимог баг, теннис эрэгтэй, эмэгтэй, шатар эрэгтэй, эмэгтэй, зуун буудалт даам эрэгтэй, эмэгтэй гэсэн 5 төрлөөр, урлагийн тэмцээн мэндчилгээ, гоцлол дуу, гоцлол бүжиг, дуэт дуу гэсэн 5 төрлөөр явагдлаа.

Тэмцээн нийт хоёр өдрийн турш үргэлжлэн багууд хурд хүч, авьяас чадвараа дайчлан амжилттай оролцсон бөгөөд спорт, урлагийн төрөл бүр дээр шүүгчийн өгсөн багуудын онооны нийлбэр дүнгээр байр эзлүүлэн аваргуудаа тодрууллаа.



### **Урлагийн наадмын төрөлд:**







1-р байр Увс аймаг "Чандмань-Увс" ХХК



2-р байр Баян-Өлгий аймаг "Суат" ХХ





**Гар бөмбөгийн төрөлд:**



1-р байр Говь- Алтай аймаг - "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ



2-р байр Ховд аймаг "Шим- Ус" ХХК





3-р байр Баян-Өлгий аймаг-"Суат" ХХК





**Сагсан бөмбөгийн төрөлд:**

1-р байр Говь- Алтай аймаг "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ

2-р байр Баян-Өлгий аймаг-"Суат" ХХК

3-р байр Завхан аймаг- "Амь- Ус Трейд" ХХК



**Теннис эрэгтэй төрөлд:**

1-р байр Увс аймаг – "Чандмань- Увс" ХХК Ерөнхий ня-бо Ц.Эрдэнэбат

2-р байр Говь- Алтай аймаг- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ Инженер Б.Сугар

3-р байр Баян-Өлгий аймаг "Суат" ХХК А.Ербол







**Теннис эмэгтэй төрөлд:**

1-р байр Говь- Алтай- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ Эдийн засагч С.Энхбаяр

2-р байр Ховд аймаг "Шим- Ус" ХХК Д.Анхбаяр

3-р байр Увс аймаг – "Чандмань- Увс" ХХК Операторчин М.Отгон

**Шатар эрэгтэй төрөлд:**

1-р байр Ховд аймаг "Шим- Ус" ХХК С.Мөнхбаатар

2-р байр Говь- Алтай аймаг- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ Г.Бат-Ирээдүй

3-р байр Завхан аймаг- "Амь- Ус Трейд" ХХК Ц.Доржготов

**Шатар эмэгтэй төрөлд:**

1-р байр Баян-Өлгий аймаг "Суат" ХХК Ш.Рапия

2-р байр Говь- Алтай аймаг- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ Ерөнхий ня-бо Должинжав

3-р байр Завхан аймаг- "Амь-Ус Трейд" ХХК Даваажаргал







**Зуун буудалт даам эрэгтэй төрөлд:**

- 1-р байр Завхан аймаг- "Амь- Ус Трейд" ХХК Ц.Доржготов
- 2-р байр Ховд аймаг "Шим- Ус" ХХК С.Мөнхбаатар
- 3-р байр Говь- Алтай аймаг- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ Б.Баатарсүх

**Зуун буудалт даам эмэгтэй төрөлд:**

- 1-р байр Говь- Алтай аймаг- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ С.Энхбаяр
- 2-р байр Увс аймаг – "Чандмань- Увс" ХХК Операторчин Е.Төмөрөө
- 3-р байр Завхан аймаг- "Амь-Ус Трейд" ХХК Даваажаргал

**Зуун буудалт даам эрэгтэй төрөлд:**

- 1-р байр Говь- Алтай аймаг- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ Б.Баатарсүх
- 2-р байр Ховд аймаг "Шим- Ус" ХХК С.Мөнхбаатар
- 3-р байр Завхан аймаг- "Амь-Ус Трейд" ХХК Ц.Доржготов

**Зуун буудалт даам эмэгтэй төрөлд:**

- 1-р байр Говь- Алтай аймаг- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ С.Энхбаяр
- 2-р байр Увс аймаг – "Чандмань- Увс" ХХК Операторчин Е.Төмөрөө
- 3-р байр Завхан аймаг- "Амь-Ус Трейд" ХХК Л.Даваажаргал

**Багийн нийлбэр дүнгээр**

- 1-р байр Говь- Алтай аймаг- "Ундарга- Алтай" ОНӨААТҮГ
- 2-р байр Завхан аймаг- "Амь-Ус Трейд" ХХК
- 3-р байр Баян-Өлгий аймаг "Суат" ХХК тус тус шалгарлаа.



Увс аймгийн "Чандмань Увс" ХХК



## **“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК НЬ ХАНГАЙН БҮСИЙН НИЙТИЙН АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНДАХ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААН, УРЛАГ, СПОРТЫН НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

"Хөвсгөл Ус Суваг" ХХК нь хангайн бүсийн нийтийн аж ахуйн байгууллагуудын дундах ажил мэргэжлийн уралдаан, урлаг, спортын наадмыг зохион байгууллаа.

Тус ажлын хүрээнд нийтийн аж ахуйн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, ажлын туршлага солилцох болон бие бялдрыг өв тэгш хөгжүүлэх, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх зорилгоор 2017 оны 05 сарын 25-28-ны хооронд Мөрөн хот болон Хатгал тосгонд зохион байгууллаа.

Хангайн бүсийн НААБайгууллагуудын дундах тэмцээн, уралдаанд дараах аймгууд оролцлоо.

1. Архангай аймгийн - "Ундарга" ХХК
2. Баянхонгор аймгийн - "Чандмань Баянхонгор" ХК
3. Булган аймгийн - "Булган Мээж" ХХК
4. Өвөрхангай аймгийн - "Онги-Ус" ОНӨХК
5. Дорноговь аймгийн - "Чандмань Бадрал" ХХК
6. Орхон аймгийн - "Эрдэнэт Ус, Дулаан түгээх сүлжээ" ОНӨХК
7. Хөвсгөл аймгийн - "Хөвсгөл Ус Суваг" ХХК

2017 оны 05 сарын 25-нд Хөвсгөл аймгийн Чингүнжавын талбайд болсон Хангайн бүсийн нээлтийн үйл ажиллагаанд Аймгийн засаг дарга Л.Ганболд, Аймгийн хууль зүйн хэлтсийн дарга Гандэлгэр, МНААҮХолбооны мэргэжилтэн Ж.Оюунцэцэг, "Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн ахмад ажилтан Н.Пүрэвцэрэн болон аймгуудын нийтийн аж ахуйн байгууллагуудын удирдлагууд оролцлоо.







Хангайн бүсийн нийтийн аж ахуйн байгууллагуудын дундах ажил мэргэжлийн уралдаан, урлаг, спортын наадамд оролцогчид





Хангайн бүсийн нийтийн аж ахуйн байгууллагуудын дундах ажил мэргэжлийн уралдаан, урлаг, спортын наадмыг дараах төрлүүдээр зохион байгууллаа.

1. Гар бөмбөгийн тэмцээн нь: Хөвсгөл аймгийн "Эрдмийн далай" сургуулийн спортын зааланд 2017.05.25-26 өдрүүдэд боллоо.



Гар бөмбөгийн холимог багийн тоглолт

2. Буухиа тэмцээн нь: Хөвсгөл аймгийн хөл бөмбөгийн 400 метрийн гүйлтийн талбайд аймаг тус бүрээс эрэгтэй-2, эмэгтэй-2 тамирчин оролцсон.





3. Шатрын тэмцээн нь: Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны "Далайн тур" амралтын газарт аймаг тус бүрээс эрэгтэй-1, эмэгтэй-1 тамирчид оролцон тойргоор тоглолоо.

4. Дартсын тэмцээн нь: Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны "Далайн тур" амралтын газарт Нийтийн аж ахуйн байгууллагуудын удирдлагуудын дунд зохион байгуулагдсан.

5. Инженерүүдийн мэдлэг, ажилчдын ур чадварыг харуулсан тус тэмцээн нь: "Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн ажлын байрны гадна талбайд аймаг тус бүрээс инженер-1, засварчин-1 оролцуулан зохион байгууллаа.



Ажил мэргэжлийн уралдаан явагдаж байгаа нь





6. Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрт 2017 оны 05 сарын 25-нд урлагын төрөлд багийн мэндчилгээ, гоцлол ардын бүжиг, гоцлол ардын дуу гэсэн 3 төрлөөр зохион байгуулагдлаа.



Хөвсгөл аймгийн "Хөвсгөл Ус суваг" ХХК





"Хөвсгөл Ус Суваг" ХХК нь хангайн бүсийн нийтийн аж ахуйн байгууллагуудын дундах зохион байгуулсан ажил мэргэжлийн уралдаан, урлаг, спортын наадамд ирсэн баг тамирчид амжилттай оролцож дараах шагналт байруудыг эзэллээ.

**Шатар Эрэгтэй:**

1-р байр Өвөрхангай аймаг "Онги Ус Суваг" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Цэвэрлэх байгууламжийн операторчин Д.Ганболд

2-р байр "Орхон аймаг Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компанийн инженер Ж.Баттулга.

3-р байр Дорноговь аймаг "Чандмань-Бадрал" ХХК—ийн гүйцэтгэх захирал У.Санрайжав

**Шатар Эмэгтэй:**

1-р байр Дорноговь аймаг "Чандмань-Бадрал" ХХК—ийн эдийн засагч Н.Хишигжаргал

2-р байр Өвөрхангай аймаг "Онги Ус Суваг" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Гэрээт борлуулалтын менежер И.Бат-Очир

3-р байр "Орхон аймаг Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компанийн нягтлан бодогч Х.Пүрэвдорж

**Дартс:**

1-р байр "Орхон аймаг Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Бүүвэйбаатар

2-р байр Булган аймаг "Булган Мээж" ХХК-ийн захирал Д.Очирбат

3-р байр Өвөрхангай аймаг "Онги Ус Суваг" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал О.Лхагвасүрэн

**Ажил мэргэжлийн уралдаан:**

1-р байр Архангай аймгийн "Ундарга" ХХК-ийн ерөнхий инженер З.Ганболд, машинист З.Гансүлд

2-р байр "Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн ерөнхий инженер Д.Сүхээ, Сантехникийн засварчин Ч.Батхүү

3-р байр Дорноговь аймаг "Чандмань-Бадрал" ХХК—ийн гүйцэтгэх захирал У.Санрайжав, Сантехникийн засварчин З. Буянхишхиг

**Буухиа тэмцээн:**

1-р байр Дорноговь аймаг "Чандмань-Бадрал" ХХК ахлагч Э. Хулан

2-р байр Баянхонгор аймаг "Чандмань Баянхонгор" ХК ахлагч Б. Тэмүүлэн

3-р байр Хөвсгөл аймаг "Хөвсгөл Ус Суваг" ХХК ахлагч Л. Нармандах

**Гар бөмбөг**

1-р байр "Орхон аймаг Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компани

2-р байр Булган аймаг "Булган Мээж" ХХК

3-р байр Өвөрхангай аймаг "Онги Ус Суваг" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

**Гоцлол бүжиг**

1-р байр Дорноговь аймаг "Чандмань-Бадрал" ХХК-ийн Хүний нөөцийн менежер Э.Хулан

2-р байр Хөвсгөл аймгийн "Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн Салбарын инженер М.Бат-Өлзий



3-р байр "Орхон аймаг Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компанийн нягтлан бодогч Г.Аянга

### **Гоцлол дуу**

1-р байр "Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн ус түгээгч Ц.Отгонжаргал

2-р байр "Орхон аймаг Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компанийн цахилгаанчин Б.Баяржаргал

3-р байр Өвөрхангай аймаг "Онги Ус Суваг" Орон нутгийн өмчит аж ахуйт тооцоот үйлдвэрийн газрын үйлчилгээний жолооч Л.Ханбогд

### **Мэндчилгээ**

1-р байр "Орхон аймаг Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компани

2-р байр Булган аймаг "Булган Мээж" ХХК

3-р байр Баянхонгор аймаг "Чандмань-Баянхонгор" хувьцаат компани

- Байгууллагын хамт олноо амжилттай зохион байгуулж оролцсон Шилдэг удирдагчаар Архангай аймгийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал М.Батболд шалгарлаа.

- Тамирчдаас онцгой амжилт гаргаж Шилдэг тамирчнаар "Орхон аймаг Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компанийн борлуулалтын байцаагч Л.Өлзийбат шалгарлаа.

### **Багийн нийлбэр дүнгээр аймгуудын байр эзэлсэн байдал:**

- 1-р байр "Орхон аймгийн Д.Бүүвэйбаатар захиралтай Эрдэнэт ус, Дулаан түгээх сүлжээ" Орон нутгийн өмчит хувьцаат компани
- 2-р байр Дорноговь аймгийн У.Санрайжав захиралтай "Чандмань-Бадрал" ХХК
- 3-р байр Өвөрхангай аймгийн О.Лхагвасүрэн захиралтай "Онги Ус Суваг" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
- 4-р байр Хөвсгөл аймгийн Г.Энхбаяр захиралтай "Хөвсгөл Ус Суваг" ХХК
- 5-р байр Булган аймгийн Б.Очирбат захиралтай "Булган Мээж" ХХК
- 6-р байр Баянхонгор аймгийн Э.Энхбат захиралтай "Чандмань-Баянхонгор" Хувьцаат компани
- 7-р байр Архангай аймгийн М.Батболд захиралтай "Ундарга" ХХК тус тус амжилттай оролцлоо.





## ГОВЬСҮМБЭР АЙМАГ “УС ДУ” ОНӨААТУГАЗАР ДАРХАН УС- СУВАГ ХК-ТАЙ ТАНИЛЦАХ, ТУРШЛАГА СУДЛАХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА


2017 оны 06 сарын 30-ний өдөр Дарханы ус суваг ХК-тай танилцаж туршлага судлах ажлыг зохион байгууллаа. Тус ажлыг 4 үе шаттайгаар зохион байгуулсан ба Үүнд:

1. Тус байгууллагатай танилцаж, холбогдох бичиг баримттай танилцсан.
2. Ус хангамжийн эх үүсвэртэй танилцсан
3. Цэвэрлэх байгууламжтай танилцсан
4. Нөхөрсөг тэмцээн зохион байгуулсан

***НЭГ. Дархан ус-суваг ХК-ийн танилцуулга, дотоод журам, хамтын гэрээ бусад хэлтсийн баримт бичигтэй танилцах.***

Тус компани нь нийт 274 ажилтантай ба Үйлдвэр эрхэлсэн дэд захирал ерөнхий инженер, Санхүү эдийн засаг хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал, санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, ХАБЭА-н инженер, Захиргаа удирдлагын хэлтэс (ЗУХ), Үйлдвэр технологийн хэлтэс (ҮТХ), Санхүү эдийн засгийн хэлтэс (СЭЗХ), Усан хангамжийн алба (УХА), Ариутгах татуургын алба (АТА), Хэрэглэгчийн алба (ХА), Орон сууцны алба (ОСА), Техник шуурхай үйлчилгээний алба (ТШҮА), Лаборатори гэсэн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компанийн танилцуулагатай танилцсаны дараа ажилчид тус бүрийн мэргэжлийн чиглэлийн дагуу холбогдох бичиг баримттай танилцаж туршлага судаллаа.







### ***ХОЁР. Ус хангамжийн эх үүсвэртэй танилцсан байдал***

Тус компани нь төвлөрсөн усан хангамжийн сүлжээгээр 1300 гаруй аж ахуйн нэгж, 12500 гаруй айл өрхүүдтэй цэвэр усаар ханган, бохир усыг татан зайлуулах гэрээ байгуулан, гэр хорооллын 28 мянга гаруй хүн амд зөөврөөр 17, төвлөрсөн сүлжээгээр 25 нийт 42 ус түгээх байруудаар дамжуулан үйлчилж байна. Тус байгууллага нь хоногт 70000 м<sup>3</sup> цэвэр ус олзворлох, хүчин чадалтай.



### ***ГУРАВ. Цэвэрлэх байгууламжтай танилцсан байдал***

Бидний танилцах ёстой дараагийн том объект бол Дархан хотын цэвэрлэх байгууламж юм. Тус цэвэрлэх байгууламж нь 50000 м<sup>3</sup> бохир усыг татан зайлуулах хүчин чадалтай ба Бохир усаа механик болон биологийн аргаар цэвэрлэдэг. Цэвэрлэх байгуумжийн цэвэршлтийн түвшин нь 94%-тай байна.







**ДӨРӨВ. Нөхөрсөг тэмцээн зохион байгууллаа.**

Мөн Дархан ус суваг ХК-тай хамтран нөхөрсөг тэмцээн зохион байгууллаа. Үүнд: Волейбол холимог баг, Эрэгтэй эмэгтэй теннис гэсэн 2 төрлөөр зохион байгуулж ялагчаа тодрууллаа.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ "УС ДУ" ОНӨААТҮГАЗАР**





## ЦУВРАЛ 4

# УС ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН УС ТҮГЭЭХ ШУГАМ СҮЛЖЭЭНД ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Ус хангамжийн эх үүсвэрээс дамжуулах шугамаар хоёрдугаар өргөх станцад ирж нөөцлөгдсөн усыг хэрэглэгчдэд хүргэх зориулалтын түгээх шугам сүлжээнд засвар үйлчилгээг явуулах, хяналт тавихад энэхүү журмыг мөрдөн ажиллана.
- 1.2. Ус түгээх шугамыг ашиглалтанд оруулах, хүлээн авахдаа "Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж" БНБД 40 – 02 – 06 болон холбогдох дүрэм, журмыг баримтлан ажиллана.
- 1.3. Ус түгээх шугам нь ундны усны чанарт нөлөөлөхөөргүй стандартын шаардлага хангасан, үйлдвэрийн чанарын баталгаатай материалаар хийгдсэн байх шаардлагатай бөгөөд угсралтын өмнө барилгын сорилт баталгаажуулалтын лабораторид шинжлүүлж дүгнэлт гаргуулсан байна.
- 1.4. Ус түгээх шугам нь хэрэглэгчийг 2 талаас нь усаар хангах боломжтой цагираг түгээх сүлжээ, нэг болон хэд хэдэн хэрэглэгчийг усаар хангах зориулалтын нэг талын усан хангамжтай мухардмал түгээх сүлжээ хэлбэрээр байж болно.
- 1.5. Ус түгээх шугамыг хаалт, галын гидрант, хий гаргагч, даралт, температур хэмжих зэрэг зориулалтын тоног төхөөрөмжүүдээр тоноглохоос гадна шаардлагатай цэгүүдэд даралт тохируулагч болон урсгал зардал хэмжигч хаалт, ус хэмжих тоолуур, шугамын ус юүлэх хаалт зэргийг суурилуулж өгнө.
- 1.6. Түгээх шугам сүлжээнд төрөл бүрийн зориулалтын тоноглол угсрахдаа тусгайлан бэлтгэсэн худагт байрлуулна. Худгийн хэмжээ ямар байх нь шугам хоолойн голч диаметр, түүнд тавигдах арматур, холбогдох хэрэгслэлийн тоо хэмжээ, байршил зэргээс хамаарна.
- 1.7. Унд ахуйн ус тээвэрлэж түгээх шугам нь хотын ус хангамжийн системийн хамгийн өндөрлөг цэг хүртэл усыг хүргэх тул шугам хоолой нь 1,6 МПА буюу 16 АТА даралт даах чадвартай байхаар төлөвлөгдөж хийгдсэн байна.
- 1.8. Ус түгээх шугаманд аваар гэмтэл гарах, засвар хийх үед хотын ус хангамжийн төвлөрсөн системийн тасралтгүй ажиллагаанд нөлөөлөхгүй байхаар, хэрэглэгчдийг хамгийн бага хугацаанд усаар тасалдуулах нөхцөлөөр тооцож хийнэ.
- 1.9. Түгээх шугамд гэмтэл гарах, ус алдах зэрэг тохиолдолд хариуцсан хэсгийн инженер, техникч нараар дамжуулан засварын албанд мэдэгдэж яаралтай засвар үйлчилгээ хийлгэнэ.
- 1.10. Шугамд суурилагдсан тоноглолуудын холбоосуудаар ус шүүрэх, хаалтны жийргээр ус гарах зэрэг жижиг гэмтлийг шугам хариуцсан эргэлтийн засварчид газар дээр нь засварлана.

### **Хоёр. Ус түгээх шугамын ашиглалт**

- 2.1. Ус түгээх шугаманд ширэм, ган, хуванцар хоолойнуудыг ашиглаж болох бөгөөд эдгээр нь ундны усыг түгээх шугам хоолойны стандартын шаардлагыг хангасан байна.
- 2.2. Худагт шугам хоолой, арматур тоноглолыг угсрахдаа худгийн доторхи гадаргуу хүртэлх хамгийн бага зайг баримтлана.
  - 2.2.1. Шугам хоолойн уртын дагуух фланцан холболтоос худгийн хана хүртэлх зай нь хамгийн багадаа:
    - а. Ф400 мм хүртэлх шугаманд 300 мм
    - б. Ф500 – 600 мм шугаманд 500 мм



- в. Ф600 мм – ээс дээш шугаманд 700 мм байна.
- 2.2.2. Шугам хоолойн доод гадаргуу худгийн ёроолоос хамгийн багадаа
  - а. Ф75 мм хүртлэх шугаманд 150 мм
  - б. Ф100 – 250 мм шугаманд 200 мм
  - в. Ф300 – 400 мм шугаманд 250 мм
  - г. Ф450 – 500мм шугаманд 300 мм байна.
- 2.3. Түгээх хоолойг ашиглалтанд оруулахын өмнө урьдчилан туршилт буюу шугам хоолойг суваг шуудуунд шороогоор булаагүй байхад нь залгаасуудын бат бэх чанарыг нүдээр харж ус шүүрч байгаа эсэхийг шалгана. Дараа нь эцсийн туршилт буюу шугам хоолойг шороогоор дарж, бүх тоноглолууд тавигдаж дууссаны дараа шахалт хийж, даралтын бууралтаар шугамын битүүмжлэлийг тодорхойлно.
  - 2.3.1. Шинээр хийсэн ус түгээх шугамыг ашиглалтанд хүлээн авахын өмнө шугамын битүүмжлэлийг тодорхойлохдоо хийгээр буюу усаар шахалт хийж туршина.
  - 2.3.2. 8 – 10 атм даралттай усаар болон 6 – 8 атм даралттай хийгээр шахалт хийж, усны алдагдал гараагүй нөхцөлд туршилт дууссанд тооцно.
  - 2.3.3. Шугамын битүүмжлэлийг шалгаж дууссаны дараа дамжуулах болон түгээх шугам хоолойг угааж халдваргүйжүүлэх ажлын зааврын дагуу шугамыг угааж халдваргүйжүүлнэ.
  - 2.3.4. Шугамыг угааж халдваргүйжүүлсний дараа уснаас сорьц авч лабораторид шинжлүүлнэ.
  - 2.3.5. Лабораторийн шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй нөхцөлд угаалга халдваргүйжүүлэлтийг давтан хийж лабораторид дахин сорьц өгч шинжлүүлнэ.
  - 2.3.6. Лабораторийн шинжилгээгээр ундны усны стандартын шаардлага хангасан нөхцөлд шугамыг хүлээж авахад бэлтгэнэ.
- 2.4. Шинээр хийсэн түгээх шугамыг ашиглалтанд хүлээн авахдаа:
  - 2.4.1. Түгээх гол шугамыг зураг төсвийн дагуу хийсэн эсэхийг шалгана.
  - 2.4.2. Гүйцэтгэлийн зургийг мэдээллийн санд бүртгүүлнэ.
  - 2.4.3. Хаалтууд, галын гидрант, хий гаргах вантуз, даралт, температурын тоног төхөөрөмжийн бэлэн байдал болон паспорт, бичиг баримтыг нэг бүрчлэн шалгаж хүлээж авна.
  - 2.4.4. Хяналтын худаг, камерын битүүмжлэлийг шалгаж, ус нэвтэрсэн эсэхийг хянаж үзнэ.
  - 2.4.5. Худагт хаалт, тоноглолуудыг зөв байрлуулж, тавигдсан эсэхийг шалгана.
  - 2.4.6. Шатны бэхэлгээ, люк, тагны даац чанарын шаардлага хангасан эсэхийг шалгана.
- 2.5. Худгийн ажлын хэсгийн өндөр нь 1,5 метрээс багагүй байх ба дотор нь хүн орж ажиллах боломжтой байхаар төлөвлөгдөж хийгдсэн байна.
- 2.6. Ус түгээх шугамыг хүйтний улиралд хөлдөхөөс сэргийлэхийн тулд:
  - 2.6.1. Газрын хөлдөлтийн цэгээс доош 0,5 м гүнд суурилуулах
  - 2.6.2. Шугамын гадуур дулаалга хийж, хяналтын худаг, камерийг дулаалгатай, давхар тагтай болгоно.
  - 2.6.3. Цахилгаанаар халаахад зориулсан халаалтын утастай хийх
  - 2.6.4. Эргэлтийн насостой байхаар төлөвлөх зэрэг арга хэмжээг авсан байна.

### **Гурав. Ус түгээх шугамд засвар үйлчилгээ хийх**

- 3.1. Ус түгээх шугамыг ус ашиглагч байгууллага хүлээн авсанаас хойшхи засвар үйлчилгээ, угаалга, цэвэрлэгээ хийх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
- 3.2. Засвар үйлчилгээ нь өдөр тутмын байхаас гадна графикийн дагуу ээлжийн болон хэсэгчилсэн, их засвар гэж ангилна.
- 3.3. Өдөр тутмын засвар үйлчилгээ, арчилгааг түгээх шугамын засварчин хариуцаж



- гүйцэтгэнэ.
- 3.4. Түгээх шугам дээр тоноглогдсон хаалт, үл буцаах клапан, хий гаргах вантуз, усны хэмжүүр, манометр, термометрууд зэрэг тоноглолуудад өдөр тутамд тосолгоо үйлчилгээ хийнэ.
  - 3.5. Шугамын хяналтын худаг, холболттой камеруудыг цэвэрлэж, усгүй хуурай байлгах, таг, люкны бүрэн бүтэн байдал, шатны бэхэлгээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг засвар үйлчилгээний ажилтан хариуцана.
  - 3.6. Сард нэгээс доошгүй удаа ус түгээх шугамаар ус түгээхийг бүрэн зогсоож, хаалтыг хааж нээж шалган голыг нь цэвэрлэж, шаардлагатай бол сальник жийргүүдийг нь сольж хэвийн найдвартай ажиллагааг хангуулж ажиллана.
  - 3.7. Засвар үйлчилгээ хариуцсан албаны дарга, инженерүүд нь ээлжийн болон хэсэгчилсэн, их засвар хийх графикийг гаргаж, тухайн шугамыг хариуцахаар томилогдсон ажлын хэсэг уг засвар үйлчилгээний ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
  - 3.8. Шугамын засвар үйлчилгээг хариуцсан ажилтнууд нь шугамын трасс тоног төхөөрөмжийн талаар сайн мэддэг, дадлага туршлагатай мэргэшсэн байх шаардлагатай.
  - 3.9. Хэсэгчилсэн байдлаар хийх засварын асуудлыг засвар үйлчилгээг хариуцаж буй цэг салбарын инженер, техникийн ажилтнуудын санал, дүгнэлт, тодорхойлолтыг үндэслэн шийдвэрлэнэ.
  - 3.10. Их засварт оруулахын тулд дараах нөхцөлүүдийг хангасан байна.
    - 3.10.1. Цэг салбар хариуцсан инженер, техникийн ажилтны дүгнэлт, тодорхойлолтыг гаргуулсан байх
    - 3.10.2. Шугам хоолойноос сорьц авч барилгын сорилт, туршилтын лабораторид шалгуулж дүгнэлт гаргуулсан байх
    - 3.10.3. Тухайн шугам хоолойны элэгдэл, хорогдлын талаархи санхүүгийн тодорхойлолтыг гаргуулах
    - 3.10.4. Шугам хоолойн бат бэх байдал, суурилагдсан тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд техникийн комиссын дүгнэлт гаргуулсан байх
    - 3.10.5. Техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн тухайн жилийн хөрөнгө оруулалт, их засварын төлөвлөгөөнд тусгуулах
    - 3.10.6. Их засварын зураг, төсвийг хийлгэх
    - 3.10.7. Их засвар хийсэн гүйцэтгэлийн зураг, төсөв, актыг үйлдэж, их засварын ажлыг хүлээн авах ажлын комиссоор шалгуулан дүгнэлт гаргуулах
    - 3.10.8. Гүйцэтгэлийн зураг, төсөв, акт дүгнэлт, бичиг баримтуудыг бүрдүүлэн байгууллагын техникийн архивт хүлээлгэн өгч хадгалуулах зэрэг арга хэмжээнүүдийг авсан байх.
  - 3.11. Ус түгээх шугаманд засвар үйлчилгээ хийсний дараа шугам, хоолойг угааж цэвэрлэж халдваргүйжүүлэх ажлыг тусгайлан гаргасан зааврыг баримтлаж гүйцэтгэнэ.

### **Дөрөв. Ус түгээх шугамын ашиглалтанд тавих хяналт**

- 4.1. Ус түгээх шугамын өдөр тутмын хэвийн найдвартай ажиллагаанд хяналт тавих үүргийг шугамын хяналтын засвар үйлчилгээний ажилчид хариуцана.
- 4.2. Шугамын хяналтын засварчид нь ус хангамжийн тоног төхөөрөмж, шугам хоолойн ашиглалт, засвар үйлчилгээний сургалтанд хамрагдсан мэргэжлийн 3 ба түүнээс дээш зэрэгтэй байна.
- 4.3. Түгээх шугамд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан тодорхой үүрэгтэйгээр ажиллуулж болно.
- 4.4. Ажлын хэсэг нь шугамын дагуу явж худгийн люкны битүүмжлэл, шугаманд суурилагдсан тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа, ус алдаж шүүрч байгаа эсэхийг шалгаж, шугамын даралтын болон температурын мэдээг авч тухайн хэсгийн инженер техникийн ажилтнууддаа танилцуулж төв диспетчерт мэдээлж байна.
- 4.5. Ус түгээх шугам, тоног төхөөрөмжүүдэд гэмтэл гарах, ус алдах зэрэг тохиолдолд





- хариуцсан хэсгийн инженер, техникч нарт мэдээлж, засварын ажлын хэсгийг дуудуулж, гэмтлийг яаралтай засварлуулах ба энэ тухай төв диспетчерт мэдээлнэ.
- 4.6. Түгээх шугамын засварчид нь өдөр бүрийн хийсэн ажил, хяналт тавьсан тухай эргэлт хяналтын дэвтэр дээр бичиж тэмдэглэнэ.
- 4.7. Түгээх шугамд хяналт тавьж буй ажилтнууд зориулалтын ажлын хувцсаа өмсөж, шаардагдах багаж, худгийн таг онгойлгох хэрэгслэлээ биедээ авч явна.
- 4.8. Түгээх шугамын хяналтын худаг, камерт орж ажиллахдаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг хатуу мөрдөж ажиллана.

## **УС ДАМЖУУЛАХ ХООЛОЙ ДАХЬ ДАРАЛТЫН ХЭЛБЭЛЗЭЛ, ГЭМТЭЛ ҮҮСЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗААВАР**

### ***Нэг. Нийтлэг үндэслэл***

1.1. Ус дамжуулах хоолойд эрчим хүчний гэнэтийн саатал гарах, усны хэрэглээ огцом нэмэгдэх буурах, шугам сүлжээний хаалтыг огцом нээж хаах, шилжилтийн процесс болон гидравлик цохилтоос үүссэн чичиргээ зэрэг шалтгаануудаас даралтын хэлбэлзэл үүсэх, элэгдэл, зэврэлт, хөлдөлт зэргээс шалтгаалан шугам хоолой гэмтэхээс урьдчилан сэргийлэхэд энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.2. Энэхүү журмын биелэлтэнд усыг дамжуулах, түгээх сүлжээний ашиглалт, технологи ажиллагааг хариуцсан инженер, техникийн ажилтнууд хяналт тавьж, гэмтэл үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

### ***Хоёр. Журмын нэр томъёоны тодорхойлолт***

Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доорхи утгаар ойлгоно.

2.1. "Ус дамжуулах шугам" гэж эх үүсвэрээс 2 дугаар өргөгчийн усан санд болон хотын төвлөрсөн ус хангамжийн системийн нөөцийн усан сан хүртэл тээвэрлэн хүргэх шугамыг хэлнэ.

2.2. "Шилжилтийн процесс" гэдэг нь нэг горимоос нөгөө горимд шилжих шилжилтийн үе шатыг хэлнэ. Энэ горимын өөрчлөлт нь даралт, усны хурд, насосны роторын эргэлтийн тоо, насосны хөдөлгүүрийн ачаалал зэрэг параметруудийн өөрчлөлтийг;

2.3. "Үндсэн шилжилтийн процесс" гэдэг нь насос ажиллах болон зогсох, хаалтны хаах, нээх хэмжээгээр зарцуулалтыг өөрчлөх, мөн зэрэгцээ болон угсраа байдлаар насос ажиллах, зогсох зэрэг системийн ажлын үндсэн процессууд байнга давтагдаж байдаг шилжилтүүдийг;

2.4. "Онцгой шилжилтийн процесс" гэдэг нь кавитацийн үзэгдэл, систем, насосны тогтвортой бус бүсэд ажиллах, насос эрчим хүчний тасалдлаас гэнэт зогсох, хоосон шугам хоолойд ус шахаж эхлэх зэрэг процессуудыг;

2.5. "Гидравлик цохилт" гэдэг нь шингэний хөдөлгөөний хурд огцом ихсэх юмуу багасахад шугам дотор даралтын өөрчлөлт үүсэхийг;

### ***Гурав. Даралтын хэлбэлзэл, гэмтэл үүсэхээс урьдчилан сэргийлэх***

3.1. Ус дамжуулах хоолойд даралтын хэлбэлзэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авна. Үүнд:

3.1.1. Ус хангамжийн шугам хоолой, хаалт, арматурын сонголтыг зөв хийх;

3.1.2. Насосны ажиллах горим, параметрийг зөв тодорхойлох;

3.1.3. Өргөх болон дамжуулан шахах насос станц дахь насоснуудад зөөлөн асаалттай хувьсах зарцуулалттай, эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмж суурилуулах;

3.1.4. Хянах, хэмжих хэрэгслэлийг бүрэн бүтэн байлгаж, ашиглалтанд хяналт тавих, мэдээллийн дэвтэрт бүртгэж, диспетчерт тогтмол мэдээлж байх;

3.1.5. Автомат тохируулагчтай системийг хэрэгцээт хэсгүүдэд тавьж өгөх;



- 3.1.6. Даралт тохируулагч, бууруулагч тоног төхөөрөмжийг шугаманд суурилуулж өгөх;
- 3.1.7. Үл буцаах хавхлаг суурилуулах;
- 3.1.8. Дамжуулах хоолойн уртыг анхаарч төлөвлөх;
- 3.1.9. Шилжилтийн процесс, гидравлик цохилтоос хамгаалах арга хэмжээг зураг төсөлд тусгах;
- 3.1.10. Шугамын угсралтыг БНБД 40.02.06 "Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж" нормд заасны дагуу баримталж гүйцэтгэх;
- 3.1.11. Дамжуулах шугам хоолойн зураг төсөл болон угсралтын ажилд тавих хяналтыг сайжруулах;

### **Дөрөв. Хамгаалалтын арга хэмжээ**

- 4.1. Гадна ус хангамжийн дамжуулах сүлжээнд дараах хамгаалах арга хэмжээг авсан байх шаардлагатай.
  - 4.1.1. Автомат тохируулагчтай хаалтуудыг шаардлагатай газруудад нь суурилуулж хэвийн ажиллагаанд нь байнга хяналт тавих
  - 4.1.2. Урьдчилан хамгаалах хавхлаг суурилуулах
  - 4.1.3. Шаардлагатай гэж үзвэл горимын тохируулга хийх
  - 4.1.4. Сүлжээний хамгаалалтын зурвасыг тэмдэгжүүлэх
  - 4.1.5. Дамжуулах хоолойн трассын дагуу болон дээр нь барилга байгууламж баригдаж байгаа эсэхэд байнга хяналт тавих

### **Тав. Дамжуулах шугамд гэмтэл үүсэхээс урьдчилан сэргийлэх**

- 5.1. Дамжуулах шугамд эвдрэл, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх
- 5.2. Дамжуулах шугамын эмзэг хэсэгт эвдрэл, гэмтэл гарах, хагарах, газрын хөрс хөлдөх, гэсэх зэргээс үүдэн суулт, овойлт үүсч бурзан холбоос задрах, зэврэлтээс хоолой цоорох, хаалт хагарах зэргээс сэргийлж дараах арга хэмжээг авна.
  - 5.2.1. Холбогдох норм ба дүрэм, стандартын дагуу гадна шугам хоолойн зураг төсөл зохиох угсралтын ажлыг гүйцэтгэх
  - 5.2.2. Цэвдэгтэй хөрсөнд шугам хоолойг нэвтрэх сувагт угсрах
- 5.3. Гэмтэл үүссэн тохиолдолд авсан арга хэмжээнд акт үйлдэнэ.
  - 5.3.1. Актыг журмын хавсралтын дагуу бичиж, уг ажлыг удирдсан, оролцсон хүмүүс гарын үсгээ зурсан байна.

### **УС ДАМЖУУЛАХ ХООЛОЙД ДАРАЛТЫН ХЭЛБЭЛЗЭЛ, ГЭМТЭЛ ҮҮССЭН ҮЕД ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН АКТ**

Алба, нэгжийн нэр: .....

Байршил: .....

Шугам хоолойн төрөл, хийц: .....

Анх ашиглалтанд орсон он, сар, өдөр: .....

Эвдрэл, гэмтэл үүссэн он, сар, өдөр: .....

Эвдрэл, гэмтлийг засахад оролцсон ажилтны нэр: .....

Эвдрэл, гэмтлийг засахад оролцсон ажилтны албан тушаал: .....

Эвдрэл, гэмтэл үүссэн шалтгаан: .....

Эвдрэл, гэмтлийн үед авсан арга хэмжээ: .....

1. ....

Акт үйлдсэн албан тушаалтан:

.....

овог, нэр, албан тушаал

..... он .... сар .... өдөр





## «ДЭД БҮТЭЦ ТӨВЛӨРСӨН УХААЛАГ ТЕХНОЛОГИ»



### МЭНДЧИЛГЭЭ

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Ц.НАСАНБАТ:

НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 86 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ "ДЭД БҮТЭЦ ИНЖЕНЕРИНГ" КОМПАНИЙН НИЙТ ХАМТ ОЛНЫ ЗҮГЭЭС ДЭВШҮҮЛЖ, ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧИЛЭЛ, ХӨГЖИЛ ДЭВШИЛТЭД ӨНДӨР АМЖИЛТ ХҮСЬЕ.

### УС БОЛ ҮНЭЛЭГДЭХ ЁСТОЙ ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ

Усны хэрэглээг зохистой ашиглах талаар орон сууцны барилгын ашиглалтын үйлчилгээ, цахилгаан сантехникийн магистраль, шугам сүлжээ, инженерийн тоног төхөөрөмжийн угсралтын үйлчилгээ эрхэлдэг "Дэд бүтэц инженеринг" ХХК-ийн Ерөнхий захирал Ц.Насанбат ярьж байна. Дашрамд дурьдахад, тус компани 2017 оны Барилгын салбарын шилдэг 10 байгууллагын нэгээр шалгараад байгаа юм.

*-Ярилцлагын өмнө ундны ус зөвхөн нийслэлчүүдийн төдийгүй дэлхий нийтийн анхаарлын төвд орсон асуудал. Усыг зохистой ашиглах талаар таны байр суурь болон танай компанийн явуулж байгаа үйл ажиллагааны тухай сонирхож асуух нь зөв байх гэж бодож байна?*

-Дэлхийн гадаргын 70 хувийг ус бүрхдэг. Гэхдээ зөвхөн нэг хувь нь ундны усанд тохиромжтой. Олон улсын байгууллагууд 2020 он гэхэд дэлхийн долоон тэрбум хүний 47 хувь нь цэвэр усны хүрэлцээгүй нөхцөлд амьдарна гэсэн тооцоог гаргасан байдаг. Манай улсын усны нөөц 608.000 сая шоо метр. Энэ нь дэлхийн усны нөөцийн 0.0004 хувь юм. Энэ бол ундны усны зохистой хэрэглээг бий болгох, Монгол Улсын стандарт нормд тохирсон олон улсын хэмжээнд ашиглагдаж буй шинэ техник технологи бүхий ус хэмжигч хэрэгсэлийг нэвтрүүлэхийг сануулсан баримт. Энэ утгаараа "Ус бол үнэлэгдэх ёстой чандмань эрдэнэ" гэж бид үздэг. Усны зохистой хэрэглэнэ гэдэг асуудал нь өөрөө зөвхөн энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын асуудал биш л дээ. Иргэн бүр, айл өрх бүр л энэ сэдэвт санаа тавьж байх ёстой юм.

Манай компани байгуулагдсан цагаасаа орон сууц нийтийн аж ахуй, тэр дундаа усны зөв хэрэглээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Үүний зөвхөн нэг том алхам бол бид орон сууцны айл өрхүүдэд ОХУ-д үйлдвэрлэгдсэн "Арзамас" брэндийн тоолуурыг боломжийн үнээр тогтмол, найдвартай нийлүүлж ирсэн явдал.



*-Усны тоолуурын "Арзамас" брэнд иргэдэд танил болоод удаж байна. Бүтээгдэхүүний чанарын хувьд иргэдийн сэтгэлд хэр зэрэг нийцэж байна вэ?*

-ОХУ-ын "Арзамасский приборостроительный завод имени П.И.Пландина" буюу "АПЗ" үйлдвэр 1957 онд байгуулагдсан. Цэргийн болон иргэний гэсэн хоёр ангиллаар үйлдвэрлэл явуулдаг. Үйлдвэрийн 21 хувь ОХУ-ын төрийн мэдэлд байдаг. Манай улсад 2014 оноос тоолуур нийлүүлж эхэлсэн. Бид Стриж "Аква 1" ухаалаг тоолуурыг оруулж ирж байгаа. Тоолуурын хувьд чанартай, далавчит хүрд нь мөнгөн бүрхүүлтэй тул нян устгах шинж чанар агуулсан. Бүгд үйлдвэрийн явцад шат шатандаа чанарын хяналтаар шалгагддаг. Тоолуурын битүү механизм нь хөлрөх, тоос шороо орохоос хамгаалагдсан, тасралтгүй 12 жил найдвартай ажиллах эд. Оросын бүтээгдэхүүн чанартай гэдэг утгаар манай хэрэглэгчид нь хурдан дасч байгаа.

*-Ер нь улсын хэмжээнд тоолууржуулалт ямар хэмжээнд явагдаж байгаа бол. Энэ талаар танд мэдээлэл байна уу?*

-Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар нийтдээ 93 мянган өрх болон 7500 гаруй аж ахуйн нэгжийг ус дулаанаар хангаж ажилладаг. 2012 онд усны тоолууржилт 49 хувьтай байсан бол 2016 онд 67 хувьтай явж байсан. Ирэх дөрвөн жилд усны тоолууржилтыг 100 хувьд хүргэхийн тулд нийт 30 мянга гаруй өрхөд 120 мянга гаруй усны тоолууржилт шаардлагатай байгаа. Айл өрхийн усны хэрэглээг тоолууржуулснаар 2000 оны үед жилд дунджаар 61.0 сая шоо метр ус түгээж байсан бол 2015 онд 55.0 сая шоо метр ус түгээсэн нь нийслэлийн хэмжээнд 18.0 хувиар буюу 6.0 сая шоо метр ус хэмнэсэн үзүүлэлт гарсан.

Нийслэлийн хэмжээнд тоолуур тавиулаагүй байгаа 30 гаруй мянган айл өрхөө яаралтай тоолууржуулж амжихгүй бол Улаанбаатарчууд ундны цэвэр усны нөөцийнхөө 20 хувийг сул асгаж, урсгаж байна гэсэн үг. Өөр нэг баримт хэлэхэд Монгол Улсын нийт хүн амын 30.5 хувьд





төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс ундны усаа авч хэрэглэж байна. Харин 35.8 хувь нь зөөврийн ус тээврийн үйлчилгээнээс, 24.6 хувь нь ус түгээх байр, худгаас, 9.1 хувь нь булаг, шанд, гол горхиноос усаа авч хэрэглэдэг юм. Энэ бол Улаанбаатар хотын ундны усны нөөц, ашиглалт, хамгаалалтыг хариуцдаг төрийн байгууллагуудын санааг зовоож байгаа асуудал мөн.

**-Танай компани энэ онд усны тоолуурын хэмжигч лаборатори оруулж ирсэн гэж дуулсан. Энэ талаараа мэдээлэл өгөхгүй юу?**

-Манай компанийн импортлож байгаа стриж "Аква 1" ухаалаг тоолуур бидний хэрэгжүүлж буй "Дэд бүтэц телематик" удирдлагын төвийн хяналтанд багтдаг. Энэ тоолуурыг тавьсан айл өрхүүд гар утсанд суурилсан аппликейшны тусламжтайгаар ундны усны хэрэглээний мэдээллээ өдөр, сар бүр үнэгүй авдаг болж байгаа юм. Нөгөө талаар орон сууцны конторууд хэрэглэгчдийн хэрэглээний заалтын мэдээллээ компьютерт суулгасан программын тусламжтайгаар бүрэн гүйцэд авдаг болсон. Ингэснээр орон сууцны конторын ажилчид сар бүр айл өрхийн хаалгыг тогшихгүй болж, айл өрхүүд ч ажил амралтын өдрөөр хаалга үүдээ тогшуулж, ариун цэврийн өрөөний буланд байх тоолуур жижиг заалт руу тонголзохгүй болж байгаа юм.

Ийм хэрэглээг нэвтрүүлж байгаагийн хувьд бас дэвшил хийх ёстой гэж үзээд ОХУ-ын "Арзамас" тоног төхөөрөмжийн үйлдвэр хамтран усны тоолуурыг ухаалаг системд шилжүүлэх шинэ технологийг нэвтрүүлж өдөрт 1000 ширхэг тоолуур хэмжих хүчин чадал бүхий лаборатори Сүхбаатар дүүрэгт байрлах "Pro One" оффиссын байрандаа нээсэн. Лабораторитай болсноор нэгдүгээрт аливаа усны хэрэглээний мэдээллийг цуглуулахад их хялбар болж байгаа юм. Хоёрдугаарт тоолуурын заалт үнэн зөв байна. Өөрөөр хэлбэл хэн нэгэн тоолуурын заалтыг өөрчлөх гэсэн оролдлого гарвал шууд төв дээр мэдэгдэнэ. Хэдэн цагт ямар хүчтэй магнитаар үйлчилсэн болохыг тэр дор нь тодорхойлно. Гуравдугаарт хэрэглэгчдэд маш амар байна. Хэн нэгэн очоод усны тоолуурыг чинь авъя, цахилгааны заалтыг чинь авъя гэсэн зүйл огт байхгүй болно. Нэмж хэлэхэд энэхүү ухаалаг технологийг ашиглахад маш хялбар үнийн хувьд хямд юм.

## **“ТЕЛЕМАТИК УДИРДАГЫН ТӨВ” ТӨВЧ ТАНИЦУУЛГА**

ОХУ-с болон БНКазахстан Улсын хэд хэдэн хотуудад нэвтрүүлсэн "СТРИЖ" телематик мэдээллийн системийг манай хамт олон НААҮ-ний салбарт "ДЭД БҮТЭЦ УХААЛАГ ШИЙДЭЛ" төслөөр амжилттай хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн зорилго: "АРЗАМАС" брэндийн хэмжих хэрэгслийг илүү боловсронгуй болгосноор усны хэрэглээг хянах автоматжуулахад оршино.

Тус удирдлагын төв нь ашиглалтанд орсноор орчин үеийн хотуудын өмнө тулгарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд түлхэц үзүүлнэ. Жишээ нь: Агаарын бохирдол, авто машины зогсоол, усны бохирдол, авто замын ачаалал болон бусад нарийн мэргэжлийн хэмжих хэрэгслүүдийн мэдээллийг зайнаас авах, хянах, удирдах боломжтой болох юм.






Монголд анхдагч LPWAN удирдлагын төвийн нээлтийн ажиллагаа амжилттай боллоо.



Засвар үйлчилгээний нэгдсэн төв/ухаалаг лаборатори/ нээлтээ хийлээ  
Манай компани нь 2017 оны 08-р сарын 16-нд "Ухаалаг" бүрэн автомат лабораторийг ашиглалтанд орууллаа.







Тус лабораторийн тоног төхөөрөмж нь хоног/ажлын 8 цагт/-т 1200 ширхэг усны тоолуур шалгах хүчин чадалтай. Бусад лаборотариудтай харьцуулахад дараах давуу талуудтай.

Үүнд:

- Гар ажиллагааг багасгаснаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлснээр иргэдэд хүндрэл учруулахгүй болсон
- Лаборатори нь 72 цагийн турш тасралтгүй ажиллах хүчин чадалтай
- Дэлгэц болон хянах самбарууд нь мэдрэгчтэй тул ажиллахад хялбар
- Программд өгөгдлийг нэг удаа оруулснаар тоолуур шалналтын үр дүнг автоматаар бодохоос гадна шалгалтанд тэнцсэн эсэхийг шууд мэдээллэдэг
- Усны даралт, температур, жин зэрэг бүх шаардлагатай үзүүлэлтүүдийг хяналтын самбарт харах бүрэн боломжтой
- Тухайн ажилтнуудын хэзээ ажиллаж, хэр хэмжээний тоолуур шалгасныг дараа хянах бүрэн боломжтой
- Цахилгаан тасарсан үед мэдээллийг хадгалахаар программчлагдсан
- Ямар ч тоолуурын серийн дугаарыг гар аргаар шивэхгүйгээр автоматаар мэдрэгчтэй төхөөрөмжөөр өгөгдлийг оруулах боломжтой.
- Хэрэв тоолуурын шалгалтаар гарсан үр дүнг эргэлзээтэй гэж үзсэн тохиолдолд гар аргаар давхар шалгаж болно.
- Бүх эд анги нь сайн чанарын зэвэрдэггүй материалаар хийгдсэн тул ашиглалтын хугацаа урт байна.
- Улсын байцаагч нь жингийн болон эзэлхүүний аль ч аргаар хяналт тавих боломжтой



**“ДЭД БҮТЭЦ  
ИНЖЕНЕРИНГ” ХХК**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 6 дугаар сарын 16-ны  
өдөр

Улаанбаатар хот

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Ерөнхий зүйл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Хувь хүний орлогын албан татвар /цаашид "албан татвар" гэх/-ын тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчээс бусад хувь хүний орлогод албан татвар ногдуулах харилцааг энэ хуулиар зохицуулна.

##### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "гадаад улсад олсон орлого" гэж албан татвар төлөгчийн гадаад улсад хөдөлмөр эрхлэх, үйл ажиллагаа явуулах, хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, эрх өмчлөх, эзэмших, ашиглах, шилжүүлэх, худалдах замаар олсон орлого болон мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг;

*/Энэ заалтад 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

4.1.2. "малчин өрх" гэж хувийнхаа өмчийн малыг байнга маллаж, ашиг шимээр нь үндсэн орлогоо олдог гэр бүлийг;

4.1.3. "мал бүхий этгээд" гэж энэ хуулийн 4.1.2-т зааснаас бусад мал өмчилж байгаа хувь хүнийг;

4.1.4. "суутгагч" гэж албан татвар төлөгчийн орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ Албан татвар төлөгч

##### 5 дугаар зүйл. Албан татвар төлөгч

5.1. Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасан албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга оршин суугч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч гэж ангилна.

##### 6 дугаар зүйл. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч

6.1. Дараахь хувь хүнийг Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч гэж үзнэ:





6.1.1. Монгол Улсад оршин суух байртай;  
6.1.2. тухайн татварын жилд 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад амьдарсан;

6.1.3. гадаад улсад томилогдон ажиллаж байгаа Монгол Улсын төрийн албан хаагч.

6.2. Энэ хуулийн 6.1.2-т заасан хугацааг Монгол Улсын хилээр орсон өдрөөс хуанлийн хоногоор тоолох бөгөөд олон удаа орж гарсан тохиолдолд албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хоногийн нийлбэрээр тодорхойлно.

6.3. Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүд нь Монгол Улсад оршин суугчид хамаарахгүй.

### **7 дугаар зүйл. Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч**

7.1. Монгол Улсад оршин суух байргүй, тухайн жилд 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин суугаагүй хувь хүн нь оршин суугч бус албан татвар төлөгч байна.

7.2. Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хугацааг энэ хуулийн 6.2-т заасны дагуу тодорхойлно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **Албан татвар ногдох орлого, албан татвараас чөлөөлөх орлого**

#### **8 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого**

8.1. Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараахь орлогод албан татвар ногдуулна:

8.1.1. цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;

8.1.2. үйл ажиллагааны орлого;

8.1.3. хөрөнгийн орлого;

8.1.4. хөрөнгө борлуулсны орлого;

~~8.1.5. /Энэ заалтыг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

8.1.6. шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

8.1.7. урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал;

8.1.8. төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого;

8.1.9. шууд бус орлого.

#### **9 дүгээр зүйл. Албан татвар ногдох орлогыг тодорхойлох**

9.1. Дор дурдсан журмыг баримтлан албан татвар ногдох орлогыг тодорхойлно:

9.1.1. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаад улсад олсон орлогод албан татвар ногдуулна;

9.1.2. Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогод албан татвар ногдуулна;

9.1.3. албан татвар төлөгч өөрөө буюу түүний өмнөөс хөрөнгө оруулсан, хуримтлуулсан бол уг хөрөнгийг албан татвар ногдох орлогод оруулан тооцсоныг албан татвар төлөгч нотлох үүрэгтэй бөгөөд хэрэв нотолж чадахгүй бол оруулсан хөрөнгө, хуримтлалын дүнг албан татвар төлөгчийн тухайн жилийн татвар ногдуулах орлогын дүнд оруулан тооцно;

9.1.4. бараа, ажил, үйлчилгээний хэлбэрээр хийгдсэн албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнийг жишиг болгоно;

9.1.5. харилцан хамаарал бүхий этгээдүүд зах зээлийнхээс хямд, эсхүл өндөр үнээр хоорондоо бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн, бараа, хөрөнгө



шилжүүлсэн бол харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын зах зээлийн үнийг жишиг болгон татварын алба тодорхойлно.

9.2.Гадаад валютаар олсон орлого, гарсан зардлыг төгрөгт шилжүүлэхдээ Монголбанкнаас тогтоосон тухайн өдрийн ханшийг үндэслэнэ.

#### **10 дугаар зүйл. Харилцан хамаарал бүхий этгээд**

10.1.Албан татвар төлөгчтэй дор дурдсан харилцаатай бол “харилцан хамаарал бүхий этгээд” гэж үзнэ:

10.1.1.тухайн албан татвар төлөгчийн эцэг, эх, хүүхэд, өвөө, эмээ, ач, зээ бол;

10.1.2.тухайн албан татвар төлөгчийн ах, эгч, дүү, эсхүл тэдний хүүхэд бол;

10.1.3.тухайн албан татвар төлөгчийн эхнэр, нөхөр, эсхүл тэдний эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү бол;

10.1.4.тухайн албан татвар төлөгчийн буюу энэ хуулийн 10.1.1-10.1.3-т заасан харилцан хамаарал бүхий хувь хүний хяналтад байдаг хуулийн этгээд.

#### **11 дүгээр зүйл. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого**

11.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараахь орлого хамаарна:

11.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

11.1.2.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;

11.1.3.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;

11.1.4.төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

11.1.5.гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал;

11.1.6.үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого.

#### **12 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлого**

12.1.Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр бие даан мэргэжлийн үйлчилгээ, үйлдвэрлэл, арилжаа эрхэлж олсон дараахь орлогыг хамруулна:

12.1.1.эмч, хуульч, өмгөөлөгч, архитекторч, нягтлан бодогч, багш зэрэг мэргэжлээр ажиллаж олсон үйлчилгээний орлого;

12.1.2.хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлого.

12.2.Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

#### **13 дугаар зүйл. Хөрөнгийн орлого**

13.1.Хөрөнгийн орлогод дараахь орлого хамаарна:

13.1.1.түрээсийн орлого;

13.1.2.эрхийн шимтгэлийн орлого;

13.1.3.ногдол ашгийн орлого;

13.1.4.хүүгийн орлого;

13.1.5.өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг бусдад ашиглуулснаас олсон орлого.

13.2.Түрээсийн орлогод хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө түрээслүүлсний орлого хамаарна.

13.3.Эрхийн шимтгэлийн орлогод дараахь төлбөр хамаарна:

13.3.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасан зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг ашигласны төлбөр;





13.3.2. Патентийн тухай хуульд заасан шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар ашигласны төлбөр;

13.3.3. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн дагуу барааны тэмдэг ашигласны төлбөр;

13.3.4. Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу технологи дамжуулсны төлбөр;

13.3.5. Үйлдвэрлэл, худалдааны талаархи болон шинжлэх ухааны туршилттай холбогдсон мэдээллийг ашигласны төлбөр;

13.3.6. Энэ хуулийн 13.3.1-13.3.5-д заасантай адилтгах бусад эрх ашигласны төлбөр.

13.4. Энэ хуулийн 13.1.3-т заасан ногдол ашгийн орлогод хувь нийлүүлсэн хуулийн этгээдээс ашиг хуваах, хувь хүртээх хэлбэрээр авсан мөнгөн болон мөнгөн бус орлого, түүний хүү хамаарна.

13.5. Энэ хуулийн 13.1.4-т заасан хүүгийн орлогод зээлийн хүү, харилцах дансны үлдэгдэл, мөнгөн хадгаламжийн хүү, батлан даалт гаргасны төлбөр, өрийн бичиг /бонд/, хууль болон гэрээний дагуу авч байгаа хүү, анз хамаарна.

#### **14 дүгээр зүйл. Хөрөнгө борлуулсны орлого**

14.1. Хөрөнгө борлуулсны орлогод дараахь орлого хамаарна:

14.1.1. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;

14.1.2. Хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;

14.1.3. Хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого.

#### **15 дугаар зүйл. Шууд бус орлого**

15.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараахь бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна:

15.1.1. Үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн, түүнчлэн бэлнээр олгосон унааны мөнгө;

15.1.2. Орон сууцны ашиглалтын зардлын төлбөр, бэлнээр олгосон байрны хөлс, түлшний зардал;

15.1.3. Бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор;

15.1.4. Ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгчийн болон бусад үйлчилгээ үзүүлсний зардал;

15.1.5. Ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;

15.1.6. Арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;

15.1.7. Энэ хуулийн 15.1.1–15.1.6-д заасантай адилтгах бусад орлого.

15.2. Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараахь шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамааруулахгүй:

15.2.1. Тухайн ажлын байранд ажлын цагаар ажиллуулдаг цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан;

15.2.2. Суурин газраас алслагдсан ажлын байранд ажилладаг ажиллагсдыг амрах байр, бусад үйлчилгээгээр хангах, тухайн ажлын байранд ирэх, буцахад нэгдсэн журмаар унаагаар үйлчилсэн;

15.2.3. Орон сууц худалдан авах, барихад зориулж ажилтанд арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;

15.2.4. Эмчилгээний зардал.

15.3. Энэ хуулийн 15.1-д заасан шууд бус орлогыг ажил олгогчоос уг орлогыг олгохтой холбогдон гарсан зардлын дүнгээр тодорхойлно.

#### **16 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх орлого**

16.1. Дараахь орлогыг албан татвараас чөлөөлнө:



16.1.1.хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж;

16.1.2.донорын олговор;

16.1.3.албан томилолтын зардал;

16.1.4.даатгалын нөхөн төлбөр;

16.1.5.Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын болон Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;

[/Энэ заалтад 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

[/Энэ заалтад 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

16.1.6.хууль тогтоомжийн дагуу олгож байгаа хөдөлмөр хамгааллын болон дүрэмт хувцас, хор саармагжуулах ундааны үнэ, тэдгээртэй адилтгах бусад хангамжийн үнэ;

16.1.7.гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэдэд үзүүлж байгаа тусламж;

16.1.8.энэ хуулийн 6.3-т заасан хувь хүний цалин, нэмэгдэл;

16.1.9.энэ хуулийн 16.1.8-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн гадаад улсад олсон орлого;

16.1.10.хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого;

16.1.11.Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал;

16.1.12.хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого.

16.1.13.малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлого.

[/Энэ заалтыг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

16.1.14.Монгол Улсын нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, үйлдвэрлэн борлуулах үйл ажиллагаанаас олсон орлого.

[/Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

16.1.15.албан татвар төлөгчийн өөрийн хэрэгцээнд зориулан худалдан авсан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээтэй тэнцэх орлого.

[/Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

16.1.16.мөнгөн хадгаламжийн нийт хэмжээ нь 100 сая төгрөгөөс дээш нэг жил ба түүнээс бага хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн хүүгийн орлогоос бусад Монгол Улсын иргэний мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд

[/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ заалтад 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ заалтыг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

16.1.17.соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн хандив.

[/Энэ заалтыг 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

16.1.18.нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллаас орсон орлого.

[/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

16.2.Албан татвар ногдох орлогын дүнд албан татвараас чөлөөлөгдөх орлого хамаарахгүй.



16.3.Энэ хуулийн 16.1.14-т заасан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг, 16.1.15-д заасан тоног төхөөрөмж, бараа, материалын жагсаалтыг тус тус Засгийн газар батална.

*/Энэ хэсгийг 2011 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсэгт 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

**17 дугаар зүйл. Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох**

17.1.Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

17.1.1.энэ хуулийн 11.1.1, 11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр;

17.1.2.энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан орлогын тухайд нийлбэр дүнгээр нь.

**18 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох**

18.1.Үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12.1.1-12.1.3, 12.1.5-12.1.14, 12.1.17, 12.1.19-12.1.26-д заасан зардлыг хасч, 12.2, 12.3, 12.5-12.8-д заасан зарчмыг баримталж 13-15 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан хасагдах зардал баримтаар нотлогдоогүй бөгөөд тухайн үйл ажиллагаатай холбоогүй, түүнчлэн албан татвар төлөгч хувийн хэрэгцээндээ зарцуулсан бол албан татвар ногдох орлогоос хасахгүй.

18.3.Албан татвар төлөгчийн гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож хасагдах зардалд тооцно.

18.4.Албан татвар төлөгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал тэдгээрийг хасагдах зардалд тооцохгүй.

18.5.Албан татвар төлөгч нь үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж байгаа машин, механизм, тоног төхөөрөмж, барилгыг гэр бүлийнхээ хэрэгцээнд нэгэн зэрэг ашиглаж байгаа бол ашиглалтын зардлыг хувь тэнцүүлэн тооцож хасагдах зардалд тусгана.

**19 дүгээр зүйл. Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох**

19.1.Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

19.1.1.хөрөнгө түрээслүүлснээс олсон нийт орлогоос тухайн хөрөнгийг түрээслүүлэхтэй холбогдон гарсан зардлыг хассан зөрүүгээр нь;

19.1.2.эрхийн шимтгэлийн орлогыг дүнгээр нь;

19.1.3.ногдол ашгийн орлогыг дүнгээр нь;

19.1.4.хүүгийн орлогыг дүнгээр нь;

19.1.5.өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгөө бусдад ашиглуулж олсон орлогыг дүнгээр нь.

19.2.Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол тухайн аж ахуйн нэгжийн үлдсэн эд хөрөнгийг худалдаж олсон орлогоос татвар төлөгчийн хүртсэн хувийг тодорхойлохдоо түүний хувь нийлүүлэхдээ гаргасан зардлыг хасч тооцно.

19.3.Албан татвар ногдуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг тодорхойлохдоо албан татвар төлөгчийн тухайн банкин дахь нийт хадгаламжийн хүүгийн орлогоос энэ хуулийн 16.1.16-д заасан чөлөөлөгдөх хадгаламжийн хүүгийн орлогыг хасч тооцно.

*/Энэ хэсгийг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/*

*/Энэ хэсгийг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

**20 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох**





20.1.Хөрөнгө борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

20.1.1.үл хөдлөх эд хөрөнгө борлуулснаас олсон орлогыг дүнгээр нь;

20.1.2.хувьцаа борлуулсны орлогын тухайд түүнийг борлуулсан үнээс уг хувьцааг худалдаж авсан үнийг хассан зөрүүгээр нь;

20.1.3.хамтран эзэмшиж байсан хувьцааг борлуулсан бол энэ хуулийн 20.1.2-т заасны дагуу хассан зөрүүг тодорхойлсны дараа тухайн албан татвар төлөгчид ногдох хэсгийн үнийн дүнгээр нь;

20.1.4.хувьцаа бусад үнэт цаас борлуулсан тохиолдолд нийт хувьцаа, бусад үнэт цаас худалдсан үнээс тэдгээрийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн нийт дүнг хассан зөрүүгээр нь;

/Энэ заалтыг 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

20.1.5.хөдлөх эд хөрөнгө борлуулснаас олсон орлогоос тухайн хөрөнгийг худалдан авсан болон ийнхүү худалдан авахтай холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлыг хассан зөрүүгээр нь.

**21 дүгээр зүйл.-/Энэ зүйлийг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/**

**22 дугаар зүйл. Бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох**

22.1.Дор дурдсан орлогод ногдуулах албан татварыг дараахь байдлаар тодорхойлно:

22.1.1.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

22.1.2.урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагналын орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн шагналын орлогын дүнгээр;

22.1.3.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

22.1.4.шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр.

**22<sup>1</sup> дүгээр зүйл.Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох**

22<sup>1</sup>.1.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

22<sup>1</sup>.2.Оршин суугч бус албан татвар төлөгчид орлого олгогч этгээд нь суутгагчийн үүрэг хүлээж энэ хуулийн 22<sup>1</sup>.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод албан татвар ногдуулж, суутгал хийнэ.

*/Энэ зүйлийг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө /*

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Албан татварын хувь, хэмжээ

**23 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ**

23.1.Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна.

23.1.Энэ хуулийн 17 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд дараахь хувь хэмжээгээр тооцож, албан татвар ногдуулна:

Д/д	Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хувь хэмжээ
1	18 000 000 хүртэл	10 хувь
2	18 000 000, түүнээс дээш 30 000 000 хүртэл	1 800 000 төгрөг дээр 18 000 000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 15 хувийг нэмнэ.



- 3 30 000 000, түүнээс дээш 42 000 000 3 600 000 төгрөг дээр 30 000 000 төгрөгөөс хүртэл дээш орлогын дүнгийн 20 хувийг нэмнэ.
- 4 42 000 000, түүнээс дээш 6 000 000 төгрөг дээр 42 000 000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 25 хувийг нэмнэ.

*/Энэ хэсгийг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*

23.2.Энэ хуулийн дараахь зүйл, заалтад дурдсан орлогод дор дурдсан хувь, хэмжээгээр тооцож албан татварыг тусгайлан ногдуулна:

23.2.1.энэ хуулийн 20.1.1-д заасан орлогын дүнд 2 хувиар;

23.2.2.энэ хуулийн 22.1.1-22.1.2-т заасан орлогын дүнд 5 хувиар;

23.2.3.энэ хуулийн 22.1.3-т заасан орлогын дүнд 40 хувиар.

23.2.4.энэ хуулийн 18, 19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар;

*/Энэ заалтыг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*

23.2.5.энэ хуулийн 221 дүгээр зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 20 хувиар.

*/Энэ заалтыг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө /*

[23.3./Энэ хэсгийг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

#### 24 дүгээр зүйл. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх

24.1.Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт 84000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

*/Энэ хэсэгт 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар “84 000 төгрөгийн” гэснийг “120 000 төгрөгийн, 2019 онд 160 000 төгрөгийн, 2020 онд 200 000 төгрөгийн, 2021 оноос эхлэн 240 000 төгрөгийн” гэж өөрчлөлт оруулсан бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*

[24.2./Энэ хэсгийг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

[24.3./Энэ хэсгийг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

[24.4./Энэ хэсгийг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

24.5.Дор дурдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн буюу тариалсан Монгол Улсад оршин суугч хувь хүний зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө:

24.5.1.үр тариа;

24.5.2.төмс, хүнсний ногоо;

24.5.3.жимс, жимсгэнэ;

24.5.4.тэжээлийн ургамал.

24.6.Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

24.7.Суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид суралцагчийг энэ хуулийн 24.6-д заасан хөнгөлөлтөд хамааруулна.

#### 25 дугаар зүйл. Гадаад улсад төлсөн албан татварт хөнгөлөлт үзүүлэх



25.1.Хувь хүнээс гадаад улсад төлсөн албан татварт хөнгөлөлт үзүүлэхдээ орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай гэрээний дагуу шийдвэрлэнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах

#### 26 дугаар зүйл. Албан татвар ногдуулах, төсөвт төлөх

26.1.Энэ хуулийн 4.1.4-т заасан суутгагч албан татвар ногдуулахдаа дор дурдсан журмыг баримтална:

26.1.1.энэ хуулийн 11 дүгээр зүйл, 12.2, 13.1.2-13.1.4, 15.1-д заасан орлогын дүнд мөн хуулийн 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дүнд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын дүнд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дүнд 23.2.3-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.2.энэ хуулийн 11.1.1-д заасан албан татварыг сар бүрийн эцэст ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.3.энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан албан татварыг тухай бүр нь ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.4.энэ хуулийн 11.1.6-д заасан албан татварыг уг орлогыг олгох тухай бүрт ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх;

26.1.5.аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг албан татвар төлөгч нь энэ хуулийн 16.1.12, 24.6-д заасан хөнгөлөлт эдлэх бол татварын алба ажил олгогчтой албан татварын жилийн эцсийн тооцоо хийхдээ уг хөнгөлөлтийг албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасч тооцох;

26.1.6.банк, санхүүгийн байгууллага албан татвар төлөгчийн мөнгөн хадгаламжид хүү бодох бүрдээ энэ хуулийн 23.1-д заасан хувиар албан татвар ногдуулан суутгаж, тухай бүр холбогдох төсөвт шилжүүлэх.

26.1.7.суутгагч нь энэ хуулийн 221 дүгээр зүйлд заасан орлогыг оршин суугч бус албан татвар төлөгчид олгох тухай бүр энэ хуулийн 23.2.5-д заасан хувиар албан татвар ногдуулж, тухай бүр холбогдох төсөвт шилжүүлэх.

*/Энэ заалтыг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/*

26.2.Суутгагч энэ хуулийн 26.1.2-26.1.5-д зааснаар гүйцэтгэсэн ажиллагааг албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийж баталгаажуулна.

26.3.Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.

#### 27 дугаар зүйл. Албан татварыг төсөвт төлөх

27.1.Албан татвар төлөгч албан татвар ногдуулах орлогоо энэ хуулийн дагуу өөрөө үнэн зөв тодорхойлж, дор дурдсан хугацаанд албан татварыг төсөвт төлнө:

[27.1.1./Энэ заалтыг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

27.1.2.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татварыг энэ хуулийн 23.2.1-д заасан хувиар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор;

27.1.3.түрээсийн орлогод ногдох албан татварыг энэ хуулийн 23.1-д заасан хувиар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор;

27.1.4.энэ хуулийн 12 дугаар зүйл, 13.1.5, 14.1.2, 14.1.3-т заасан орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар тооцон улирал тутам албан татвар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор.

27.1.5.гадаад улсад олсон энэ хуулийн 13.1.4-т заасан мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогод ногдох албан татварыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл энэ хуулийн 23.1-д заасан хувиар, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн энэ хуулийн 23.2.4-т заасан хувиар ногдуулан дараа сарын 10-ны дотор.

*/Энэ заалтыг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/*





27.2.Албан татвар төлөгч энэ хуулийн 11.1.6, 12 дугаар зүйл, 13.1.1, 14.1.2, 14.1.3-т заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар, 8.1.6-д заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.2.2-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулан төлж, албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулах бөгөөд татварын жилийн эцэст уг албатай татварын тооцоо хийнэ.

[27.3./Энэ хэсгийг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

[27.4./Энэ хэсгийг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

### **27<sup>1</sup> дугаар зүйл. Албан татварт хасалт хийх, буцаан олгох**

27<sup>1</sup>.1.Хувь хүн энэ хуулийн 16.1.12-т заасны дагуу албан татвар ногдох орлогын чөлөөлөлт, 24.6-д заасны дагуу албан татварын хөнгөлөлт эдлэх бол тухайн хувь хүний холбогдох төсөвт төлөх албан татвар, албан татвар ногдох орлогыг хасч тооцож болно.

27<sup>1</sup>.2.Энэ хуулийн 27<sup>1</sup>.1-д заасны дагуу тухайн жилд хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих албан татварын дүнгээс их байвал татварын алба дараахь байдлаар зохицуулна:

27<sup>1</sup>.2.1.дараагийн сар, улирал, жилд төлөх албан татварт шилжүүлэн тооцох;

27<sup>1</sup>.2.2.хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсөвт төлөх бусад төрлийн албан татварын төлбөрт шилжүүлэн тооцох.

27<sup>1</sup>.3.Энэ хуулийн 27<sup>1</sup>.1-д заасны дагуу тухайн жилд хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд албан татвар ногдвол зохих хувь хүний орлогын дүнгээс их байвал татварын алба дараагийн сар, улирал, жилд ногдох албан татвар ногдох орлогын дүнд шилжүүлэн тооцно.

27<sup>1</sup>.4.Илүү төлсөн албан татварыг дор дурдсан журмаар албан татвар төлөгчид буцаан олгоно:

27<sup>1</sup>.4.1.албан татварыг илүү төлсөн албан татвар төлөгч нь түүнийг буцаан авах хүсэлтээ татварын тооцоо хийж, тайлан тушаах үедээ харьяалах татварын албанд бичгээр гаргах;

27<sup>1</sup>.4.2.харьяалах татварын алба энэ хуулийн 27<sup>1</sup>.4.1-д зааснаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан хянаж, буцааж олгох албан татварын хэмжээг тодорхойлон, энэ тухайгаа албан татвар төлөгчид бичгээр мэдэгдэж, албан татвар төлөгчийн нэр, регистрийн дугаар, харилцагч банкны дансны дугаар, буцааж олгох албан татварын хэмжээг тодорхойлсон саналыг ажлын 5 өдөрт багтаан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид хүргүүлэх;

27<sup>1</sup>.4.3.аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн асуудал эрхэлсэн нэгж энэ хуулийн 27<sup>1</sup>.4.2-т заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан албан татварыг буцаан олгох.

27<sup>1</sup>.5.Албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27<sup>1</sup>.6.Буцаан олгох албан татвар нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн жилд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 20 хувиас хэтрэхгүй байна.

[/Энэ зүйлийг 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

### **28 дугаар зүйл. Албан татварын тайланг хүргүүлэх хугацаа**

28.1.Суутгагч нь энэ хуулийн 8.1.7, 8.1.8, 11 дүгээр зүйл, 13.1.2-13.1.4, 14.1.1, 15 дугаар зүйлд заасны дагуу суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд ирүүлнэ.

28.2.Энэ хуулийн 8.1.6, 11.1.6, 12.1.1, 12.1.2, 12.2, 13.1.1, 13.1.5, 14.1.2, 14.1.3, 15 дугаар зүйлд заасан орлогын албан татвар төлсөн тайланг хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлангийн хуудсаар гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор татварын албанд хвргүүлнэ.

**НАЙМДУГААР БҮЛЭГ****Бусад****29 дүгээр зүйл. Албан татвар төлөгчийг бүртгэх**

29.1. Үндэсний татварын алба албан татвар төлөгчийг дараахь журмаар бүртгэнэ:

29.1.1. албан татвар төлөгч нь тухайн нутаг дэвсгэрийнхээ татварын албанд бүртгүүлж, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар авах;

29.1.2. албан татвар төлөгч нь татвар төлөгчийн бүртгэлийн дугаар авахдаа бүртгэлийн маягт авч бөглөх;

29.1.3. татварын алба нь татвар төлөгчийн дугаар бүхий гэрчилгээг татвар төлөгчид олгох;

29.1.4. суутгагч нь иргэнд орлого олгох бүрдээ түүний татвар төлөгчийн дугаарыг орлого олгосон тухай баримтад тэмдэглэж, иргэн бүрт олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж мэдэгдэх.

29.2. Энэ хуулийн 29.1.2, 29.1.3-т дурдсан маягт, гэрчилгээний загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

*/Энэ хэсэгт 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

**30 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

30.1. Энэ хуулийг 2007 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

30.2. Энэ хуулийн 13.1.3, 13.1.4-т заасан орлогод 2013 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан татвар ногдуулна.

*/Энэ хэсэгт 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА****Ц.НЯМДОРЖ**



## “ДЭНЖ ХОТХОН” ХХК-ИЙН ЗАХИРАЛ ЦЭРЭНДЭМБЭРЭЛИЙН ДЭЭДЭНЦЭЦЭГТЭЙ ЯРИЛЦЛАА.

**Түүний Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт хийж бүтээснийг өндрөөр үнэлж Нийслэл хот байгуулагдсаны 378 жилийн ойгоор “Алтан гадас” одонгоор шагнасан байна.**



**Юуны өмнө танд “Алтан гадас” одонгоор шагнагдсанд баяр хүргэе. Энэхүү шагнал нь таны хүйтэнд хөрж, халуунд халж, ажлаа хар бор гэж гололгүй чин сэтгэлээсээ хичээж хөдөлмөрлөсний тань үр шим байх. “Алтан гадас” одонгоор шагнагдах үеийн сэтгэгдлээ хуваалцахгүй юу?**

Юуны өмнө энэ системд мөр зэрэгцэн ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа үе үеийн ахмадууд, ажилтан, ажиллагсдаа энэ өдрийн галтай цогтой эрчтэй хүчтэй мэндийг хүргие. Мөн танай хамт олонд ажлын амжилтыг хүсье. Төрийн дээд одонгоор энгэрээ мялаалгасандаа сэтгэл маш өндөр байна. Одон гардаж авах тэрхэн агшинд тэнгэрт байгаа аав ээж 2-гоо л их бодлоо доо.

**Та сурч байсан сургууль, эзэмшсэн мэргэжил, ажил хөдөлмөрийн гараагаа хаанаас хэрхэн эхэлж байсан, НААҮ-ний салбартай амьдралаа яаж холбосон талаар сонирхуулаач.**

Миний бие нь 1985 онд ПДС-ийн эрчим хүчний факультетийн Дулааны инженерийн ангийг төгсөөд Ноосны үйлдвэрийн нэгдэлд

боловсон хүчний зааварлагчаар хувиарлагдаж байсан минь амьдралын маань нэг алхам байлаа. Миний дунд ах Баасанжав ОСНААҮГ-ын даргаар ажиллаж байсан үе юм. Би 12 хүүхдийн хамгийн отгон нь аавдаа нилээд эрх охин байлаа. Тиймээс ах маань орон сууцанд ажиллаж чадахгүй чам шиг уйланхаа, эрх хүн бүр ч чадахгүй гээд НҮН-д оруулсан маань тэр юм. Уул нь багш нар маань намайг ОСНААҮГ-т оч ах чинь байгаа гээд НААҮЯ-д хувиарласан, гэтэл ах маань хувиарыг минь солиод Ноосны үйлдвэрийн нэгдэлд мэргэжлээс маань өөр ажилд оруулсан юм. Гэвч инженер гэж дуудуулах их гоё санагдаад ахыг Москва хот руу ажлаар явахад нь ОСНААҮГ-ын ерөнхий инженер Пунцагдэлгэр инженерт очоод би орон сууцанд л ажилд ормоор байна, би инженер болно гээд диплом, хөдөлмөрийн дэвтэр 2-оо аваачаад өгчихсөн. Удалгүй намайг дуудаад ОСА-ын 3-р конторт Дагвадорж даргатай очиж уулз гэдэг байгаа. Ингээд л 1989 оны 03-р сард диспетчери хэмээх албан тушаалд томилогдсноор ОСНАА хэмээх их айлын үүдийг алхсан нь 2 дахь том алхам байлаа.

**НААҮ-ний салбарт тасралтгүй 29 жил ажилласан танд олон сайхан дурсамж, байгаа байх. Онцолж дурьдвал...**

НААҮ-ний салбарт тасралтгүй 29 дэхь жилдээ ажиллаж байна. Хөгтэй явдал гэвэл олоон олон. Анх диспетчери хийгээд 24 цагаар хонож ажиллана. Засварчин цахилгаанчинтайгаа хамт гарна, залуу байсан болоод тэрүү их айна, ялангуяа хулганаас их айдаг, нөгөө 2-ыгоо дуудлаганд явчихаар





орой ширээн дээрээ гараад суучихдаг байсан. Гэтэл нэг өдөр дарга ороод ирсэн, сандраад ширээнээсээ үсрээд буулаа гэсэн чинь утсаа татаж унагаагаад дарга өө за за манай компаний орлого орохгүй байсан чинь чи ширээ дээр суугаад өрөнд оруулаад байгаа юм байна шүү дээ гэж билээ. Бас нэг намар шугам хагараад хонож ажиллаа, гэтэл үүрээр даараад өрөө рүүгээ ороод танкын хар хэмээх өвлийн хувцсаа өмсөөд гараад ирсэн чинь ерөнхий инженер дэлгүүр гүйгээд ундаа хиамаа автаад ир гээд явууллаа. Үүрийн 4 цаг л өнгөрч байсан байх, дэлгүүрийн худалдагч нар бүгд нойрмог, зарим нь лангуугаа дэрлээд зүүрмэглэсэн янзтай, гэтэл намайг харснаа зунаар өвлийн нэхий дотортой томдсон хар куртик өмссөн эмэгтэй ороод ирэнгүүт оргодол гэж бодсон байх бүгд дэр хийтэл босоод миний авсан ундааг хураагаад авчихдаг байгаа. Би шөнө хонож ажиллаж байгаа юмаа гэж хэлж чадахгүй ичээд хоосон гараад ирж билээ.

### ***Та ямар үед ажлаараа хамгийн их бахархдаг вэ?***

Өвлийн оргил хүйтний үед шугам хагарах маш хэцүү тэр үед оношоо олоод ажлаа дуусган, оршин суугчиддаа ус, дулааныг түгээхэд хамгийн бардам бахархал шүү дээ. Харамсалтай нь манай оршин суугчид баярлалаа гэдэг үгийн маш ховор хэлдэг дээ.

### ***Та энэ олон жил ажиллахдаа ажлаасаа халширч шантарч байв уу. Тэр л ажил миний хамаг тэвчээр, чадлыг шавхсан даа гэж бодогдох юм уу?***

Үгүй шүү шантарч, халширч байсангүй. 2005 онд байхаа 15-р хорооллын конторт ерөнхий инженерээр ажиллаж байхад Баянхошууны орон сууцны барилга хөлдөж, бүх конторуудыг дайчлан аваарийн байдалтай ажиллахдаа подвалиар нь өвдөг татмаар бохирт орж байхад л хүнд байсан даа.

### ***Та гэр бүлийнхнийхээ тухай яриач. Таны ажил хөдөлмөрийг гэрийнхэн тань хэр сайн ойлгодог вэ?***

Би ам бүл 3. 2 охин маань аварь гарах, шөнийн цагаар ажиллах үед хоолоо хийж идээд эгч нь дүүгээ өвөртлөөд унтчихсан байдаг байсан даа. Гэтэл одоо ам бүл 9-үүлээ болжээ. Том охин маань ээжийнхээ мэргэжлийг эзэмшээд дулааны автоматикийн

инженер болсон мөн л НААҮ-ний салбарт 10-аад жил ажиллаж байна даа. Ингээд бодоход миний мэргэжлийг дэмждэг байхаа.

### ***Салбарыхан таныг энэ системд тасралтгүй 29 жил үр бүтээлтэй, эрч хүчтэй ажилласнаар тань илүүтэй мэддэг. Таны энэ их эрч хүч, ажлын арга барилын нууц юунд оршиж байна.***

Салбартаа 29 жил ажиллаж байна. Бидний ажил бол буянтай ажлаа. НААҮ салбар надад өгөөжөө өгч Төрийн дээд одонгоор шагнасанд туйлын баярлаж явна даа. Ажлын арга барилын нууц гээд байх юм юу байхав дээ. Аливаа ажлыг сэтгэл зүрхээрээ хийх хэрэгтэй гэж биднийг сургадаг байжээ. Одоогийн залуучууд ажил хийхээсээ илүү шалтаг тоочих нь их болжээ. Бас үг даахгүй, залхуу бэлэнчлэх сэтгэлгээтэй болжээ. Ажлын цаана гарах, иргэд, оршин суугчиддаа сэтгэл хангалуун үйлчлэх нь миний зарчим.

### ***Таны хобби юу вэ?***

Миний хобби янз бүрийн хоол, салат хийж үр хүүхэд, найз нөхдөө дайлах, ногоо дарах, жимсээр варанье хийх, чөлөөт цагаараа агаарт гарах, хааяа найз нөхөдтэйгөө хөзөр даалуу тоглох бас гоё шүү

### ***Аливаа хүнд байгууллагын, салбарын шагнал, хамт олны хүндлэл их урам дэм өгдөг. Харин та "Алтан гадас" одонг хэр их хичээл зүтгэлээр хүртлээ гэж бодож байна?***

Нэг салбартаа он удаан жил ажилласан нь миний бахархал юм уу даа. Мэдээж Төрийн дээд шагнал надад зүгээр хялбар олдсонгүй, он удаан жилийн хөдөлмөр, зүтгэл, үр бүтээл, сэтгэл, хамт олны маань итгэл найдвар, ах дүү, найз нөхдийн маань дэмжлэг энэ бүгд шингэсэн гэж бодож байна. Энэ шагнал надад эрч хүч, халун дулаан итгэл сэтгэл өглөө.

Та бүхэнд баярлалаа. Мэргэжил нэгтэй НААҮ-ны салбарын нийт бүрэлдэхүүнд удахгүй болох шинэ оны мэндийг дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, инээд баясал бүхнийг хүсэн ерөөе.

### ***Үүгээр ярилцлагаа өндөрлөе. Өөрийн ажлын арга барил, үзэл бодлоо хуваалцсан танд баярлалаа.***

Сургалт хариуцсан менежер **Б.Алтантуул**



## УС НЬ ТАРГАЛАЛТ, ХАВДАР, ЧИХРИЙН ШИЖНЭЭС СЭРГИЙЛЭХ БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ ЭМ ЮМ.

### Арван тавдугаар бүлэг Цуврал 15

#### Нэгдүгээр бүлэг ТАРГАЛАЛТ

#### **Зориудын бус усгүйжилтийн шууд үр дагавар**

#### **Усгүйжилт нь яагаад өвчин үүсгээд байна вэ?**

Хариулт нь маш энгийн. Яагаад гэвэл орчин үеийн анагаах ухаан суурилж байгаа шинжлэх ухааны үндэслэл нь хэд хэдэн буруу таамаглалыг агуулж байгаа юм. Сүүлийн 100 жилийн хугацаанд маш их хөрөнгө заран хийсэн өвчний талаарх судалгаануудад хэн нь ч гэсэн тэр таамаглалууд нь эргэлзээтэй эсэхийг гарган тавихыг оролдоогүй. Намайг гарч ирэх хүртэл энэ асуудалд ямар ч эцэс төгсгөл харагдахгүй байсан.

Энэ бүлгийг уншиж дууссанаар та бүхэн усгүйжилтийн гол үндэс нь юунд оршиж байгааг олж мэдэх болно. Энэхүү аймшигтай алдааны хохирогч нь ганцхан та болоогүй гэдэг нь тодорхой болно. Та бүхнээс авсан мөнгийг дэмий, үр ашиггүй хоосон төсөлд зарцуулж байсан эмч судлаач нар ч гэсэн сохор байсан нь ил болно.

Энэ бүх хугацаанд эмч нар хэсгийн усгүйжилтийн үед илэрдэг янз бүрийн шинж тэмдгүүдэд тусгай нэр өгч улмаар тэдгээр шинжүүдийг өвчний жагсаалтанд оруулсаар ирсэн. Тэд бие махбодод ус дутагдсаны дүнд үүсэх янз бүрийн хүндрэлүүдийг анагаахын шинжлэх ухаанд гарсан шинэ нээлт гэж үзэж улмаар цаашид дахин гүнзгийрүүлэн судлахын тулд илүү их мөнгө хэрэгтэй гэж нэхэх болсон.

Энэ алдааг би өөрийнхөө гашуун туршлагаар мэдэрсэн бөгөөд иймээс энэ номонд бичигдсэн мэдээлэл нь анагаах

ухааны ирээдүйн талаарх ойлголтын үндэс суурь нь болох юм.

Миний нээлт бол анагаах ухаанд гарсан цоо шинэ хувьгал бөгөөд физиологи нь анагаах ухааны ноён оргил болохыг харуулсан явдал юм. Энэ нь өвчтэй хүмүүсийг мөнгө олох эх үүсвэрээ болгон ашигласаар ирсэн эм үйлдвэрлэгчдийн дарангуйллаас анагаах ухааны салбарыг татан гаргах юм.

Орчин үеийн анагаах ухааны бүх бүтцийн үндэс суурь болсон шинжлэх ухааны түлхүүр мэдээллүүдийг бий болгох явцад олон сая хүний эрүүл мэндийг хохироож үхэлд хүргээд байсан алдаанууд байгааг би олж харсан.

Хүний бие махбодод ус дутагдаж байгаа талаарх ойлголт дээр нь эмийн үйлдвэрүүд мөнгө үйлдвэрлэж, тэдгээр нь хүмүүсийг тахир дутуу болгож байлаа.

Миний хэлсэн үгнүүдийн баталгааг 1998 оны 4-р сарны 15-ны өдрийн болон 2003 оны 11-р сарын 21-ны өдрийн "Washington Post" сонины дугааруудаас уншиж болно.

#### **The Washington Post**

#### **1998 оны 4-р сарны 15, Лхагва гариг**

#### **Эмчийн олгосон эмнүүд нь олон хүний амь насыг авч одсоор байна**

#### **Сая сая хүн хордлогод ороод байна**

Рик Вейсс, "Washington Post"

Сүүлийн үед судалгаа хийсэн судлаачдын нэг нь "Эмчийн бичиж олгосноор болон зааврынх нь дагуу ууж хэрэглэж буй эмүүдийн улмаас жил бүр 2 сая хүн хүнд



өвчнөөр өвдөж, тэдгээрээс 106 мянга нь нас барж байна" гэсэн дүгнэлт гаргажээ. Ийм өндөр тоо нь эмийн гаж нөлөөнөөс шалтгаалсан нас баралтыг АНУ-ын хүн амын нас баралтын түгээмэл шалтгаануудын дотор зургаадугаарт магадгүй дөрөвдүгээрт оруулжээ.

### **The Washington Post**

2003 оны 11-р сарны 23, Баасан гариг

Шинжлэх ухааны үндэсний академийн конгрессоор батлагдсан Анагаах ухааны хүрэлэнгийн илтгэлүүд нь хууль зүйн хувьд хүчингүй ч маш нөлөөтэй юм. 4 жилийн өмнө тавигдаж байсан илтгэл хамгийн багаар тооцоход жил бүр 44 мянган америк хүн, магадгүй 98 мянга хүртэл хүн эмнэлгийн байгууллагын алдаанаас болж нас барж байна гэж бичсэн нь олон жилийн турш суурь анагаах ухааны судлаачид бүх нийтийн анхаарлыг хандуулах гэж оролдсон тэр асуудалд бүхнийг хандуулж чадсан. "Өвчтөнүүдийн аюулгүй байдал: Эрүүлийг хамгаалахын шинэ стандарт шаардлагатай байна" гэсэн шинэ илтгэл нь "Хүнд алдах зүйл байдаг" гэсэн өмнөх илтгэлд дурдагдсан асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болсон.

Хэрвээ та 2 өгүүлэлд дурдагдсан тоог нэмж үзвэл 204 орчим мянган хүн эм ууснаасаа болж нас барж байгаа бол сая сая хүн эм уухын өмнө биеийн байдал нь мууддаг гэдгийг харах болно. Гэхдээ энэ бол бүгдийг нь харуулсан тоо биш шүү.

Хамгийн харамсалтай нь өөрсдийнх нь үйлдвэрлэж буй эмүүд нь ямарч үр дүнгүй гэдгийг эмийн үйлдвэрүүд мэддэгт оршиж байгаа юм. Британийн алдартай сонинуудын нэг "Independent" сонинд ингэж бичсэн байна- энэ баталгаа шүү.

### **THE INDEPENDENT**

2003 оны 12-р сарын 8, Даваа гариг

**Эмийн үйлдвэрийн том компани "Glaxo"-ийн захирал: "Манай эмүүд ихэнх өвчтөнүүдэд үйлчилдэггүй".**

"Эмүүдийн ихэнх нь –бараг 90 орчим хувь нь хүмүүсийн 30-50 хувьд нь л нөлөөлдөг гэж Розес эмч хэлсэн. Энэ нь ихэнх эмүүд нөлөөлдөггүй гэсэн үг бишээ. Энэ нь ихэнх эмүүд нь хүмүүсийн 30-50 хувьд нь л нөлөөлдөг гэж байгаа юм. Зах зээл дээр худалдаалагдаж буй эмүүд нь хүнд нөлөөлдөг, гэхдээ бүгдэд нь биш".

Эмийн үйлдвэрүүд нь ямар ч үр дүнгүй эмүүд худалдаалж хэрхэн сая сая долларын ашиг олдог гэж та бодож байна? Эмийн үйлдвэрүүд нь өөрсдийн мөнгөний тусламжтайгаар Засгийн газрын болон анагаах ухааны салбарын толгойлох байгууллагуудад өөрсдийгөө төлөөлөх дуу хоолойтой болсон бол тэд үүнийгээ хэрэгжүүлж бүрэн чадна.

### **Бүтэн сайны хавсралт мэдээ**

#### **Los Angeles Times**

2003 оны 12-р сарын 7

Нууц нэгдэл: Эмийн үйлдвэрүүд ба анагаах ухааны судалгаа шинжилгээний засгийн газрын алба

АНУ-ын эрүүл мэндийн үндэсний хүрээлэнгийн зарим тэргүүлэх эрдэмтэд нь биоанагаах ухааны компануудаас цалин болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах эрхийн бичиг авдаг. Ийм үйлдлүүд нь улам л нууц хэлбэрт шилжсээр байгаа.

Харин одоо нийгэмд маш их үнээр үнэлэгдэн, хүмүүсийг арчаагүй дорой байдалд оруулан үхэхээс өөр байдалд хүргэдэггүй эмийн үйлдвэрүүдийн бий болгосон үхлийн галт тэрэгний зорчигчид болгоход хүргэж байгаа шинжлэх ухааны зарим ичгүүртэй таамаглалуудаас та бүхэнд дурдья.

### **Худал таамаглал №1**

**"Ам хатах нь- бие махбод усгүйжилтэнд орсныг харуулах цорын ганц шинж тэмдэг"**

Товчоор хэлэхэд ам хатах нь анхаарвал





зохих тэр шинж тэмдэг биш юм. Эсийн дотоод хэсэг ихээр усгүйжих нь бие махбодын үйл ажиллагааг алдагдахад хүргэдэг ба гэхдээ энэ нь ам хатах шинжээр илэрхийлэгддэггүй. Биед ус дутагдах тутамд шаардлагатай усны 66 хувь нь эсээс, 26 хувь нь эсийн гадаад орчноос алдагддаг бол зөвхөн 8 хувь нь л цуснаас алдагддаг байна. Гэсэн хэдий ч цусны эргэлтийн тогтолцооноос алдагдсан усны алдагдлыг нөхөхийн тулд хялгасан судаснууд нь аажмаар агшин, улмаар өөрийн үйлчилгээний хүрээгээ багасгаж эхэлдэг. Цусны том судсуудад энэ нь нөлөөлдөггүй. Цусны бүтцэд усны дутал нь мэдэгдэхүйцээр нөлөөлдөггүй. Усгүйжсэн хэсгийн эсийн дотор хэсэгт усны дутал мэдрэгдэж эхлэхэд цусны шинжилгээнд ямар ч өөрчлөлт ажиглагддаггүй ба энэ нь бие махбодод хэсгийн физиологийн усгүйжилтийн шинж тэмдгүүд ажиглагдаж байна гэж үзэхэд хүргэдэг.

Ам хатахаас урьдчилан сэргийлэх бас нэг механизм нь биеийн бусад хэсгүүд дэх усны дутал нь зажлах ба залгихад шаардлагатай шүлсийг ялгаруулахад саад болохгүйн тулд шүлсний булчирхайнуудад очих цусны урсгалыг нэмэгдүүлэхэд оршдог.

Усгүйжилттэй холбоотой бас нэгэн чухал алхмыг тайлбарлая. Биед 2 төрлийн ус байдаг. 1-р төрлийн ус нь осмосоор холбогдсон буюу энэ нь олон чухал үүргүүдийг гүйцэтгэхэд зориулагдсан байдаг бөгөөд бусад шинэ үүргүүдийг гүйцэтгэхэд хүрэлцдэггүй. Харин нөгөө төрлийн ус нь осмосоор холбогдоогүй буюу чөлөөт ус гэж нэрлэгддэг. Чөлөөт ус шаардлагатай зарим чухал үүргийг гүйцэтгэх, шинэ химийн урвалууд зэрэгт энэ усыг ашиглаж болно. Жишээ нь, ийм төрлийн ус нь усгүйжсэн эсийн дотор нэвтэрч эсэд эргэшгүй өөрчлөлт гарахаас нь урьдчилан сэргийлж усных нь хэрэгцээг хангаж чаддаг. Усгүйжилт гэдэг нь бие махбодид уснаас хамараалтай чухал үүргүүдийг гүйцэтгэхэд шаардлагатай чөлөөт ус дутагдахыг хэлнэ. Жишээ нь, 110 кг жинтэй чихрийн шижин өвчтэй хүнд ус хангалттай байвч эсийн доторх чөлөөт ус дутагдалтай

байдаг. Цусан дах сахарын хэмжээ нэмэгдэх нь зөвхөн усыг эд эс рүү сахар зөөвөрлөхөд саад болоод зогсохгүй бас эд эсээс ус алдагдахыг ихэсгэдэг. Үүний дүнд өвчтөнийг үхэлд хүргэдэг эсийн доторх усгүйжилт улам нэмэгддэг.

Бие махбод усгүйжилтэнд орсныг харуулах нэгэн тодорхой үзүүлэлт нь шээсний өнгө юм. Хэрэв шээсний өнгө байнга цайвар бараг өнгөгүй бол бие махбодид чөлөөт ус хангалттай хэмжээгээр байгаа бөгөөд хорт хаягдлаасаа амархан ангижирч чадаж байгааг харуулна. Хэрэв шээс нь хоол хүнсээр авч байгаа пигментээс, тухайлбал витамин ууснаас хамаараагүйгээр гүн шар өнгөтэй бол бие махбод усны дуталд орсныг харуулж байгаа юм.

Бодисын солилцооноос гарсан хортой хаягдлыг гадагшлуулахын тулд бөөр нь илүү их ажиллах шаардлагатай болдог. Шээс байнгын улбар шар өнгөтэй байвал хүнд хэлбэрийн усгүйжилттэй холбоотой эрүүл мэндийн асуудлууд байгааг харуулна. Хэрвээ эдгээр асуудлууд нь одоогоор хараахан илрээгүй байгаа бол аюул нь богино хугацааны дотор зүрхний өвчний хүнд хэлбэр, тархинд цус харвалт, зүрхний шигдээсээр нас барах зэргээр илэрч болох юм.

Бие махбодын ундны усны хэрэгцээг тогтмол, хэвийн хэмжээнд байлгаснаар чөлөөт усны нөөцийг нэмэгдүүлэх боломжтой. Гэхдээ усыг аль болох байгальд байгаа байдлаар нь хэрэглэхийг хичээх хэрэгтэй. Үйлдвэрийн аргаар гарган авсан ундаанууд нь биед удаан хугацаагаар хадгалагдаж чаддаггүй учир бие махбодод байгалийн усны гүйцэтгэдэг үүргүүдийг гүйцэтгэж чаддаггүй. Ундааны үйлдвэрлэлд хэрэглэж буй ихэнх нэмэлтүүд нь усгүйжүүлэх үйлчилгээ үзүүлдэг.

Харамсалтай нь ундаа үйлдвэрлэгчдийн хүн амд түгээж буй хүчтэй зар сурталчилгаа, эдгээр ундаануудын заримынх үзүүлж буй дасал болох нөлөөлөл, үнийн бодлого зэрэг нь энгийн савлагаатайгаар зарагддаг усыг биш ундааны зах зээлийг ивээн тэтгэж залуучуудыг олзлон авсаар байна. Үр дүн



нь маш аймшигтай. Өнөөдөр залуу хүмүүс улам их таргалах болж тэд хар залуугаасаа усгүйжилтийн янз бүрийн хүндрэлүүдээр өвчлөх болсон: Илүүдэл жинтэй 5-10 насны хүүхдийн 60 хувьд нь зүрх судасны өвчний ямар нэг хүндрэл илрэх болсон. Өсвөр насныхны хувьд чихрийн шижин ба бүр артерийн даралт ихсэх өвчин ч ажиглагдах болсон.

Эсийн доторх усгүйжилт нь ам хатах шинж тэмдгийн илрэлгүйгээр үхэлд ч хүргэж болох хүнд хэлбэрийн хүндрэлүүдэд хүргэж болдог. Эсийн доторх усгүйжилтийн эдгээр шинж тэмдгүүд нь орчин үеийн анагаах ухааныг төөрөгдөлд оруулан эдгээр шинж тэмдгүүдийг өвчин гэж авч үзэхэд хүргэж байгаа бөгөөд ингэснээрээ хүнийг үхэлд хүргэдэг хортой эмүүдээр шахсаар байна.

## **Худал таамаглал №2**

*"Ус нь - олон төрлийн бодисуудыг уусгах, зөөвөрлөх үүрэг гүйцэтгээд хоосон орон зайг бөглөдөг идэвхгүй нэгдэл юм. Ус нь бие махбодын физиологийн үйл ажиллагаанд ямар нэг биеэ даасан химийн бодисын үүрэг гүйцэтгэдэггүй: бие махбод дах бүх химийн урвалуудад зөвхөн усанд уусдаг хатуу бодисууд нь оролцдог"*

Ус бол идэвхгүй бус нэгдэл бөгөөд гайхамшигтай нарийн бүтэцтэй байгалийн элемент юм. Усны молекул нь устөрөгчийн 2 атом, хүчилтөрөгчийн нэг атомоос тогтдог. Хэвийн хэмд ус нь шингэн байдаг. Цельсийн 100 хэмд ус нь хийн төлөвт шилждэг. Цельсийн 4 хэмд усны нягт хамгийн их болж 0 хэмд хатуу төлөвт шилждэг ба өвөл гол мөрний ус нь мөсөөр хучигддаг. Гэхдээ яагаад ёроолдоо хүртэл хөлддөггүй вэ? Усны амьтад амьдрахад ямар хүчин зүйлүүд нөлөөлдөг вэ?

Өвлийн улиралд гол мөрний гадаргын ус нь ёроолын болон доод гүний давхаргааны усыг бодвол нягт багатай байдаг ба энэ нь усны дээд доод давхаргуудын ус холилдоход саад болж үүгээрээ мөн мөсний зузаан

нэмэгдэхийг сааруулдаг. Энэ нь усны амьтдад амьдрах нөхцлийг нь бүрдүүлдэг ба үүнээс үзэхэд усны өөрийнх нь байгалийн зүй тогтол чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Бие махбодын усны гүйцэтгэх үүргийг 2 хувааж болно. 1-р үүрэг нь амьдралыг дэмжих үүрэг юм (ус бол тэжээлийн бодисуудыг уусгах ба зөөвөрлөх үүрэг гүйцэтгэдэг).

Үүнээс чухал нөгөө гол үүрэг нь энергийг боловсруулах үүрэг юм. Ус нь эсийн бүрхүүл дээр усны эрчим хүчийг боловсруулах үүрэгтэй: усны оролцоотойгоор явагддаг хоол боловсруулах болон гидролиз гэж нэрлэгддэг химийн урвалууд нь бие махбодод явагддаг бүхий л үйл ажиллагаануудыг эрчим хүчээр хангадаг.

Бие махбодын нэн чухал үйл ажиллагааг хангахад усны наалдамтгай чанар нь гол үүрэг гүйцэтгэдэг ба энэ нь эсийн бүрхүүлийн бүтцийг бэхжүүлэн бие махбодийн эсийн доторх амьдралыг хамгаалж байдаг.

Орчин үеийн анагаах ухаан нь зөвхөн усны амьдралыг дэмжих чанарыг л хүлээн зөвшөөрдөг. Иймээс л бид архаг зориудын бус усгүйжилтийг үхэлд хүргэх шалтгаан болдог гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй байсан байна. Усыг хангалтгүй хэмжээгээр хэрэглэхэд бие махбодын амин чухал үүргүүд нь хязгаарлагдаж эхэлдэг ба эцэстээ эдгээр нь өөрөө өөрийнхөө үйл ажиллагааг алдагдуулахад хүргэдэг байна. Иймээс та бүхний эрүүл мэндийг хамгаалан, амьдралыг дэмжиж байдаг үйл явцуудын мөн чанарыг ойлгох шаардлага эндээс л урган гарч байгаа юм. Энэ бүхнийг та бүхний өмнөөс эмийн үйлдвэрлэгчид хийчихнэ гэж хүлээхийн хэрэггүй. Таны бие махбод усыг цаг тухайд нь ууж байхыг л та бүхнээс шаарддаг. Та өөрийн бие махбодын гуйгаад байгаа юмыг нь өгөхийн оронд эмийн үйлдвэрлэгчдийн зарц болсон хүмүүсийн буруу ятгалгад орж үнэтэй эмүүдийг хэрэглэхээ зогсоох хэрэгтэй.

## **Худал таамаглал №3**

*"Хүний бие махбод нь бүх л амьдралынхаа турш усны хэрэглээгээ*



### **үр дүнтэйгээр зохицуулах чадвартай байдаг"**

Энэ бол бас л худлаа. Нас ахих тусам цангах мэдрэмж буурдаг ба амьдралын амин чухал эрхтнүүд дэх шинэхэн чавга шиг эсүүд нь хатсан хар чавга шиг болон хувирч үйл ажиллагаагаа явуулж чадахаа болих хүртэл бид улам бага багаар уусаар байдаг.

Усгүйжилт нь бие махбодыг эргэшгүй өөрчлөлтөнд оруулахаас өмнө усгүйжиж эхлэх ба илрэх эхний шинж тэмдгүүдийг нь мэдэрч сурах хэрэгтэй. Бидний бие махбод хөгшрөхийн хэрээр цангалтыг мэдрэх мэдрэмж буурдаг болохыг тооцож чадсан цагт цангалтын харамсалтай үр дагаврууд нь тодорхой болж ирдэг.

Филлипс эмч бусад судлаачдын хамтаар өндөр настангууд нь 24 цаг усгүй байсан ч гэсэн тэдэнд ус уух хүсэл төрдөггүй болохыг тогтоосон байдаг: Тэд "туршилтад оролцсон хөгшин хүмүүст физиологийн хэрэгцээ мэдэгдэхүйц байсан хэдий ч тэд цангалтын шинж тэмдгийг үзүүлэхгүй байсанд бидний нээлтийн гол нь байгаа юм" гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл тэдний усгүйжсэн бие махбодид цангалтын шинж тэмдэг огтхон ч илрэхгүй байсан байна.

Брюс эмчийн удирдлаган дор өөр бас бүлэг судлаачид 20-70 насны хооронд эсийн доторхи ба гаднах усны харьцаа 1,1-ээс 0,8 болтлоо огцом өөрчлөгдөж байгааг тогтоосон байна. Энэ нь эсийн эргэн тойронд байгаа буюу гаднах ус нь эсийн доторх уснаасаа их болж, чавга шиг байсан эсүүд нь 70 насанд хатаад хатсан хар чавгатай төстэй болдог гэсэн үг юм. Эсийн доторх усны тэнцвэрт харьцаа ингэж огцом өөрчлөгдөхөд биед янз бүрийн өвчнүүд үүсдэг ба усыг бүх биеийн эсийн бүрхүүлээр чөлөөтэй нэвтэрч байх хэмжээгээр тогтмол уух нь үүнээс зайлсхийх хамгийн шилдэг арга юм. Эсийн бүрхүүлээр ус нэвчих буюу диффузи нь 0,03см/сек-ийн хурдтайгаар явагддаг. Энэ нь үнэхээр маш хурдан байгаа бөгөөд зөвхөн холбогдоогүй буюу чөлөөт ус л ингэж хурдан нэвчих чадвартай байдаг.

Бусад элементэд осмосоор холбогдсон ус нь эсийн бүрхүүлийг нэвтрэн гарч чаддаггүй.

Бие махбодийн физиологийн үйл ажиллагаа нь усгүйжилттэй тэмцэх механизмын оролцоотойгоор байнга явагдаж байвал эсийн доторх ба гаднах усны харьцаа үндсээрээ өөрчлөгддөг. Үүний дүнд чавга шиг шинэхэн эсүүд нь хатаж хуурайшин хар чавга шиг болж, бие махбодийн үйл ажиллагаа алдагдаж эхэлдэг. Энэ асуудлыг бид дараа дэлгэрэнгүй авч үзэх болно.

### **Худал таамаглал N°4**

"Ямар ч шингэн нь бие махбодийн усны хэрэгцээг хангаж чаддаг: үйлдвэрийн ямар ч шингэн, ундаанууд нь бие махбодод яг л ус шиг үйлчилгээ үзүүлдэг"

Бүх алдаанууд дотроос энэ бол хамгийн том алдаа нь юм. Өнөөгийн нийгэмд эрүүл мэндтэй холбоотой тулгамдаж буй бүх асуудлуудын гол шалтгаан нь үүнд оршиж байгаа юм. Ундаа үйлдвэрлэгчид нь зар сурталчилгааны хүчийг ашиглан яслийн наснаас эхлээд ахмад өндөр настан хүртэлх бүх насны хүмүүсийн амьдралын хэв маягийг улам түвэгтэй болгосоор байна.

Өнөөдрийг хүртэл түгээмэл хэрэглэгдсээр ирсэн ундаанууд нь хүний бие махбодод ус шиг тийм нөлөө үзүүлдэггүй. Хэрэв та байгаль дээрх зарим ургамлууд нь кофеин ялгаруулах үйлчилгээтэйг мэддэг байсан бол энэ асуудлын гол шалтгааныг ойлгох болно. Сүү болон жимсний шүүс нь ч гэсэн хүний бие махбодийн өдөр тутмын шингэний хэрэгцээг хангаж чаддаггүй. Танд таалагддаг ч бай үгүй ч бай, ус түгээгүүрийн системийн болон савласан усны амтанд та дасах л хэрэгтэй болно. Таны хувьд хамгийн чухал нь цангалт ба усгүйжилтээс урьдчилсан сэргийлэх явдал бөгөөд таны амттай гэж үзсэн ус чинь гарт тань ороод ирнэ гэж хүлээгээд суухын хэрэггүй шүү.

**Үргэлжлэл дараагийн дугаарт**